

# www.e-pada.com

## Алтан замагт буу

Эрт урьд цагт энэ дэлхийн, сүмбэр сайхан уултай, цэнгэг сайхан нуур голтой нэгэн сайхан газар хоёр айл амьдардаг байж гэнэ. Хоёр айлын нэг нь оосор бүчгүй орд цагаан гэртэй, олон мянган малтай Наст хэмээх айл. Нөгөө нь хар модыг харуулдаж хийсэн, нарс модыг нааж хийсэн гэрэл орох цонхтой гэгээн саруул байшинтай орос Ивановых ажээ. Настынх мал маллаж амьдарна. Ивановых амуу будаа, алим жимс ургуулж амьдарна. Тэр хоёр айл нэг нэг хүүтэй юм санжээ. Олон жил айл саахалт байсан хоёр айлын хоёр хүү төрсөн ах дүүсээс ялгалгүй ижилдэн дасч, эр бие өсчээ.

Иваны хүү Вася ургаа мод шиг өндөр гоолиг, уулын бүргэд шиг харцтай сайхан залуу болж гэнэ. Настын хүү Нарангэрэлт гунан бухаар зүтгүүлэвч гулзайхгүй хүчтэй, гурван сар унтахгүй ч нойрмоглохгүй сэргэлэн эр болж гэнэ. Ус гол, нутаг хошууныхан нь тэр хоёрыг хүндлэхийн дээдээр хүндэлж, бахдахын эрхмээр бахаддаг ажээ.

Зүгийн муу зүүн хойт зүгт орших хар санаат хаан хамаг олныг түйвээж, хавьтсан ойртосноо цөлмөж байгаа юулт мэдээ хүрч иржээ. Аюул гамшиг айсуиг сонсоод ус нутгийнхан хоромхон зуур цугларч хар санаат хааныг угтаж дарахаар өдөржин шөнөжин зөвлөлдөж гэнэ. Тэгээд усанд матар адил, элсэнд арслан адил эрэмгий зоригт гурван зуун баатар эрсийг Настын хүү Нарангэрэлтээр удирдуулан явуулах болов.

Нутгийн олон хүүд нь ийм их итгэл хүлээлгэсэнд Наст өвгөн ихэд баярлан:

Нэг шорооноос ургаж, нэг усаар тэжээгдэж, өссөн нутаг усныхан та нар минь, хар эрээн могой адил, халдан ирэх дайсантай халз тулах ариун үйлсэд хайрт хүүг минь шилсэнд би баяртай байна. Миний хүү баруун гартаа барсын тэнхээтэй, зүүн гартаа арслангийн тамиртай, эр болохоор та бүгдийн итгэлийг эвдэхгүй бизээ гэж бодож байна гэж хэлэхэд олон хүмүүс баярлан шуугилдав. Хамт явах нөхөд нь уухай хашгирав.

Харин Иван өвгөн дуугүй л ийш тийшээ хэдэнтээ алхав. Эргэж тойрч хэсэг холхив. Аавынхаа байдлыг ажин зогссон Вася хүү учрыг ойлгож бүхний өмнө гарч өгүүллрүүн:

-Өнгө зүс, хэл яриа өөр боловч төрөхөөс өсөхийг хүртэл хамт амьдарсан анд нөхөд

минь ээ ! Нарангэрэлт бид хоёр нэг эхээс төрөөгүй ч нэгэн зүрхээр цохилдог юм. Атаат тэр дайсан хүчээр биднээс дугуу ч гэсэн арга залиар хавьгүй илүү. Би дайлаар одъё. Нарангэрэлт надаас дүү, гарын тамир гүйцсэн ч нурууны тэнхээ гүйцээгүй, ухаанаар хурц гэлээ ч шөнөөр худагт унаагүй балчир гэнэн байгаа юм гэхэд хурсан олон чимээгүй болов. Иван өвгөний нүдэнд баярын оч гялалзан:

-Миний бодлыг хүү минь хэлчихлээ. Хүн ардын т өлөө ингэж л чи явах ёстой. Аавын хүүгийн ачийг үзэх аргагүй цаг ирсэн байна. Хүү Васяд итгэж болно хэмээн өндөр дуугаар баясан зарлав. Олон ард Иван өвгөнийг хайрлан өрөвдөж ятгасан боловч тэр өвгөн үгээсээ буцаасангүй, Вася хүү ч явахаар хатуу шийджээ.

Унаж явах морийг шинжиж олон сайхан аргамаг хөлгийг барилсан боловч Наст өвгөн адуун сүргийн сүүлд явдаг хар алаг дааг,а даахьтай бор даага хоёрын аль нэгийг барьж авчир ! гэж зөвлөв.

Аян замын бэлтгэл хийж арав хонов. Адаг сүүлд нь явах болж гурван зуун цэрэг жагсав. Хар алаг даага унасан Вася хамаг цэргийн өмнө гарч “Аавдаа хэн хайртай вэ?” гэж өндөр дуугаар асуухад зуун цэрэг “Би” гэж хариулав. Аяны өдрийг гурав хоног хойшлуулав. Гурав хоногийн дараа хоёр зуун цэрэг жагсав. “Ээждээ хэн хайртай вэ?” гэхэд зуун цэрэг “Би” гэж хариулав. Аяны өдрийг гурав хоног хойшлуулав. Гурав хоногийн дараа зуун цэрэг жагсав. “Эхнэртээ хэн хайртай вэ?” гэхэд ерөн долоон цэрэг хариулав. Ийнхүү Вася эцэг, эх, эхнэртээ хайртай бүхнийг орхиж, эх орондоо хайртай гурван цэргээ дагуулан бялзуухай нэгийг өвөртөө хийж, алсын замд оров гэнэ.

Дөрвөн эр яваад дөрвөн сар болов. Дөрвөн жил өнгөрөв. Сураг чимээ огт үгүй. Хавар болж цас ханзран, харанхуйг халж үүрийн гэгээ манхайх цагаар Иван өвгөний байшингийн дээвэр дээр бялзуухай шулганан шулганан жиргэв. Өвгөн ихэд сандарч түүнийг харвал хүзүүнд нь дугтуй бичиг байхыг олж хараад авч үзвэл:

“Бид дөрөв дайснаа дарсан. Та нараас аюул зайлсан. гурван сайн нөхөр минь хар санаат хааныхаас зуун бээр газар амь эрсдсэн. Бялзуухай та нарт очоод иртэл лавтай гурван сайхан царс мод болсон байх вий. Би хар хааны ордон руу одов. Хэрэв миний хойноос хэн нэгэн хүн ирэх бол гурван царстай уулын оройд өвгөн Ода байгаа. тэр миний тухай, та нарын явах замыг зааж өгнө. Миний хойноос ирээд хэрэгтэй биз. Вася” гэжээ.

Ийм захиа аваад Иван өвгөн гурван шөнө, гурван өдөр гуниглан гансрав гэнэ.

Сайхан сэтгэлт Иван өвгөнийхөөс утаа ч гарахгүй, уур ч савсахгүйд сэтгэл зовсон Наст өвгөн хүрч очвол Иван хамаг явдлыг харуусан тайлбарлав.

Наст гэртээ ирээд нэг ч үг дуугарсангүй долоо хоног тонгорог билүүлэв. Долоо хоног борц нүдэв. Долоо хоног морь уяв.

Нарангэрэлт хүү учрыг олж цөхөөд уур омгоо барьж ядан тэр өдрийн нар хэвийх цагаар тэнхээт даландаа саадаг агсан орж ирэв. Наст аав нь уурласан ч үгүй, инээсэн ч үгүй, гурав хоног чанасан гунжин үхрийн мхыг өмнө нь тавиад:

-За хүү минь тайвшир ! Саадаг, нум чамд хэрэггүй болсон. Сайн санаагаа чи гэртээ орхино. Явах зам чинь асар урт, хүрэх газар чинь нэн аюултай. Иван өвгөний хүү Вася атаатнаа дарсан ч гэсэн азгүй явдал нэгэнт тохиолджээ. Аврах эсэхийг гагцхүү чи л мэдэх болжээ. Үхрийн махыг дуустал нь идэж ав. Бялзуухайг нойроос сэрэх болтол чи мөн унтаж амар. Тэр шувуу чамайг замчлах болно гээд урт цагаан сахлаа намируулан илбэв. Цогтой хар нүдээ онийлгон онийлгон ширтэв гэнэ.

-За миний хүү унасан морио өөрөөс илүү хайрлаж яваарай ! Ус, өвсийг нь дутааж болохгүй, уяа сойлтыг нь алдуулж болохгүй. Морьгүй хүн мошно шүү. Олон айлд буу, онцгой ганц айлд битгий буугаарай. Голыг өргөн гэж битгий ай, горхийг нарийхан гэж бүү бас. Настан хүнээс үг сонсож, газар заалгаж яваарай. Нар нэгэнт шингэх дөхсөн бол замд битгий гараарай гэж эцэг нь сургав гэнэ.

Нарангэрэлт хүү учир явдлыг ухаарч сая л нэг уужрав. Ухаант эцгийнхээ үгийг ширхэг дараалан цээжлэв. Ингээд Нарангэрэлт хүү гунжин үхрийн махыг дуустал идэж цадав. Бялзуухайг сэртэл хамар нойроо авав.

Нарангэрэлтийн явах өдөр болоход Наст аав нь өмнөө суулгаж хүүгийнхээ гэзгийг сүлжин өгөхдөө:

-Нас чинь залуу байна, цус чинь шингэн байна. Аюул осол нэгэнт тааралдвал гэж гээгний чинь таван дор эвхмэл тонгорог хийлээ шүү. Тэр цагт үүнийг санаарай гэж захив. Хүүгээ мордуулахдаа өлсөж цангах үе тааралдвал гэж эмээлийн чинь бүүрэгний хонгон доогуур үнхэлцгэнд багтаасан үхрийн мах хийсэн шүү. Идэвзэй, үнэрлэж яваарай! Морь чинь шувуу гүйцэж чадах боловч битгий давхиарай гэж захив. Энэ үед Васягийн аав Иван өвгөн хүрч ирэв.

-За хүү минь Вася та хоёр цугтаа төрсөн ах дүүс биш ч гэсэн, цулбууртай төрсөн хоёр шүү. Насны нар хэвийсэн бид хоёр чамайг, үхлийг тэвчин хүлээх болно. Энэ бялзуухайг авч яв. Хүрэх газрыг чинь зааж өгнө. Хүний хэлийг сайн мэднэ. Өндөр гурван царсыг санаарай, Ода хэмээх өвгөнийг мартуузай. Инээсэн бүхэн нөхөр биш шүү, уурласан болгон дайсан биш шүү хэмээн сургаал хайрлав.

Ингээд Нарангэрэлт хүү алсын замд гарч үүлтэй тэнгэрийн доогуур урт замыг даган нарийн өвсийг намилзтал, бүдүүн өвсийг бөхөлзтөл ергүүлэнхэн, хатирууланхан явав. Тэгээд тэр аавынхаа захисан ёсоор олон айлд хонож өнжин, онцгой ганц айлаас тойрон, өргөн голыг айлгүй туулж, нарийн горхийг сэрэмжлэн гаталж аяны замыг саадгүй гэтэлж явлаа.

Тийнхүү явж байтал бие нь баахан алжааж, морь нь баахан сульдаж, нар хэвийсэн

нэгэн орой замын зайдуу газар торойх нэгэн айлыг хараад унтаж амармаар санагдав. Нар нэгэнт шингэх дөхсөн бол замд битгий гараарай гэж аав захисан. Тэгээд ч олон олон айлд өнжиж хонож явлаа. Онцгой ганц айлд нэг удаа буугаад үзэхэд яадаг юм бол? гэж бодоод очихоор шийдэв гэнэ.

Нарангэрэлт хүү айлд очихынхоо өмнө “Юмыг яаж мэдэх вэ?” хэмээн үүлэн бор морио даахьтай бор даага болгож, өөрөө нусгай хүү болж хувирав. Толгойн чинээ хар гэрийн гадаа очиж “Нохой хорь!” гэсэнд хэн ч гарч ирсэнгүйд морио тушаад гэрт орвол эрүү өвдөг нь нийлэх шахсан нэгэн эмгэн нурмаа ухан сууж байна гэнэ.

Нарангэрэлт хүү эмгэний амрыг асуун мэндлэхэд эмгэн их л найрсгаар угтаж:

-За нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой жаал хүү хаанаас хаана хүрч явна даа. Өөрөө ийм жижигхэн, унасан хөлөг чинь ийм туранхай, тэгээд энэ хол газар яаж явдаг билээ? гэж асуув:

-Эмээ минь манай нутаг тийм ч холгүй. Адуу малын эрэлд яваад адаг сүүлд нь төөрөөд явж байна гэж хэвнэг харуилав. Эмгэн уулга алдаж:

-Эвий хөөрхий амьтны үр ингэж явах гэж байх уу даа. Өлсөж цангаж ядарсан байлгүй. Морь, биеэ амрааж хонож өнжөөд яв. Эмээ нь хоол, цай хийж өгье гэж сайхан загнав. Нарангэрэлт хүү өөрийгөө азгайд тооцон “Үдэш орой болсон хойно ийм настай, сайхан зантай эмээгийн ирэх гэж” хэмээн дотроо баярлан:

-Гялайлаа. Эмээ минь гээд тухлан суулаа.

Эмгэн хоромхон зуурд цай хоол базааж, Нарангэрэлтийн ууж идэх зуур унаа морийг нь аргамжив. Тэгээд од жагсаж гүйцээгүй байхад л ор дэр засч, үнсэж энхрийлэх шахав. Нарангэрэлт хүү сэтгэл ууж идэх зуур унаа морийг нь аргамжив. Тэгээд од жагсаж гүйцээгүй байхад л ор дэр засч, үнсэж энхрийлэх шахав. Нарангэрэлт хүү сэтгэл уужуу, нам нойрсчээ.

Шөнө дундын хирд, шүлэг нойрын үед салхи салхилаад ч байх шиг, хэрээ гуаглаад ч байх шиг нэг л эвгүй санагдахаар зүүдэлж байна уу даа хэмээн гайхаш алдран хөдлөх гэсэн боловч хөдөлж болсонгүй тул чимээ чагнаж, нүдээ дугуу нээж харвал эмгэн цог шиг улаан нүд эргэлдүүлэн их гал түлсэн тулгаа тойрон навсагнаж, төмөр аваа гялалзуулан тас хар царайтай, мах шиг улаан нүдтэй дөрвөн том эрийг сөгдүүлэн саваадаж:

-Би гөрөөсний мах идсээр байгаад бүр турж үхлээ. Хүний мах л идмээр байна. Тэгэхдээ бүр хүүхдийнхийг идэх юмсан. Ай, чааваас ! гэж хэрээ адил бархирч байж гэнэ. Дөрвөн харын нэг нь:

-Тайвширч үз дээ, шулмас гуай минь ! Таны хүсээд байгаа юм чинь бэлэн байгаа

юм биш үү? Бид одоохон төхөөрөөд өгье л гэхэд:

-Энэ яах вэ. Зөөлхөн сайхан зууш өөрөө аманд минь аятайхан ороод ирсэн юм. Морийг нь ч идэн, өөрийг нь ч иднэ. Тэгэхдээ би аль алиныг нь одоо ч идэхгүй, маргааш ч идэхгүй. Хол газраас яваа юм билээ. Сайн амрааж байж идэхгүй бол мах, цус нь амтгүй байгаа. Морь ч гэж дээ, муу даагыг нь би гурван уулын цаана аваачаад хадан агуйд төмөр чөдрөөр чөдөрлөөд хийчихсэн. Өөрийг нь би бугын ширээр цовдлоод тавьчихсан. Ямар вэ? хэмээн бардамнаж, баахан тайвширч дөрвөн хар зарцынхаа алж ирсэн дөрвөн бугын цусыг нь ууж, махыг нь зарц нартаа өгөхөд тэд түүхийгээр нь ховдоглон идэж ясыг нь овоолон унтах болов.

Махчин шулам:

-Та нар энэ хүүгийн дөрвөн талд нь унтах хэрэгтэй. Ганц гэж ганцаардахгүй гайхал байж мэднэ. Далан жилийн өмнө биш, долоохон жилийн өмнө дөрвөн хүн ирж,хамгийг цөлмөн залгиж байсан хайрт хүүгий минь хиар цохиж хамаг бүгдийг нь үнсэн товрог болгож газрын хязгаар далайн хөвөө рүү үлдэн хөөж одсоныг санахгүй байна уу? Ганц хүүгээс минь сураг алга. Галаар өндөглөдөг бүргэдүүд минь ч алга. Би л арга ухаантайдаа агуйн мухарт амь зулбаж гарсан шүү дээ гэж савар шүд гарган ярзайн байв. Сэгсгэр үсээ үгтээн бахирч байв. Бүтэн, бүтэн бугын махыг түүхийгээр нь идсэн бүдүүн дөрвөн эр Нарангэрэлтийн дөрвөн талд хашаалан хэвтэж унтацгаав.

Нарангэрэлтийн борхон зүрх нь пол пол цохилж, богино хавирга нь шир шир хийж, эцгийн үгийг умартан эндэж осолдсоноо харуусав гэнэ.

Шөнө дөл өнгөрөх алдад эмгэн шулам архиран хурхирав. Дөрвөн хар хүн ч доргитол хурхирав.Нарангэрэлт гэрээс гараад эндиртэл явсан газар, туулсан замаа эргэн санаж “Вася ахыгаа аварч чадахгүй замын дунд ингээд өнгөрдөг байжээ. Би ч ёстой муу эр юм даа. Бялзуухай минь хаашаа нисээ бол, хайрт хөлөг минь яаж байгаа бол?” гэж санахаас бүлээн нулимс хацрыг нь даган урсав. Бүх бие нь бадайран хөшив. Ингэж арга барагдаж, тамир алдрах үед гэнэт үснийх нь уганд хийж өгсөн тонгорог санаанд нь оров. Гэвч гэзгэндээ байгаа хутгаа авах арга ер байсангүй. Хамаг бие нь баглаатай хүлээтэй, хаашаа ч яаж ч хөдлөх нөхцөлгүй ээ.

Ингэж гунихран гансран байтал махчин шулмын өрхний цорхойгоор бялзуухай нь нисэх орж ирээд Нарангэрэлтийн хацар дээр нь суув. Нарангэрэл “За чи миний гэзэгний таван дор нэг жижигхэн тонгорог байх ёстой. Түүнийг аваад өг” гэхэд тэр сүлжсэн гэзгийг нь хоромхон зуур задалж, бяцхан тонгорог авч аманд нь зуулган, өөрөө хушуугаараа таталцан тэнийлгэв. Тийнхүү бялзуухай нь хөл, х ушуутайгаа хамжиж цовдолсон ширийг зүсч эхлэв. Хялгас тавьж үлээхэд тас хяргаж байсан хутга төмөр хуягийг ч зүсч чадах иртэй гантай байсан ажээ.

Ингэж Нарангэрэлт ширэн цовдноос гарч өндийхөд махчин шулам зарц нартайгаа дуг нойрондоо хар гэрээ яйжигнатал хурхирч байна гэнэ.

Нарангэрэлт дөрвөн зарцыг нь хага мөргөлдүүлж алаад махчин шулмыг орноос нь уг татан босгож “Морь минь хаана байна вэ, хэлж өг. Төмөр чөдрийн түлхүүр хаана байна ? гаргаж өг” гэхэд машид сандран босч, морь байгаа газрыг нь зааж, төмөр чөдрийн түлхүүрийг хүзүүнээсээ мулталж өгөөд хөх чоно болон зугтах гэхэд нь хөлнөөс нь шүүрч, эрүүг нь зааж хаяв. Хар эрэн могой болж үнс рүү шургах гэв. Хүзүүгээр нь тас атган хэлийг нь сугалан хаяв. Сарьсан багваахай болон нисэх гэв. Далавчийг нь таслан хаяж галын цог руу шидэв.

Махчин шулам орь дуу болон час, пас хийж шатав. Нарангэрэлт хар хааны эх махчин шулмыг ийнхүү дарж, хар овоохой хамаг юмыг нь шатааж, сансрын салхинд хийсгэн,хайрт хөлөг морио авч бялзуухайгаа даган аяны замаа үргэлжлүүлэв гэнэ.

Нарангэрэлт хүүгийн гэнэн томоогүй явдал үүгээр эцэс болсонгүй. Нэгэн өдөр хонь хариулж явсан жаал хүүтэй уулзаж гэнэ. Тохойн чинээ биетэй бяцхан бор хүү:

-Нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой ах гуай хаанаас хаа хүрч явна вэ? Хэрэг зориг юунд вэ? Хэт нутаг хаана вэ? гэж мэнд мэдэж, хэрэг лавлаж гэнэ. Нарангэрэлт “Биеэр жижигхэн боловч яасан хэлэмгий хүүхэд вэ” гэж бодоод:

-Хэт нутаг холгүй. Хэрэг зориг малын эрэлд явж байна. Чамайг хэний хэн гэдэг вэ? гэж асуухад:

-Нурмангалт хааны хоньчин нусгай жур гэдэг байна.

Ах таныг би андуураагүй бол малын эрэлд биш, хүний эрэлд яваа юм бишүү? гэхэд:

-Яаж байна? хэмээн цочисхийн асуулаа.

-Малын эрэлд яваа хүн эхлээд мал руу хардаг, хүний эрэлд яваа хүн хүн рүү хардаг. Та тэртээ холоос ирэхдээ хонь руу биш, над руу харж ирэхлээр чинь л би тэгж таасан юм хэмээн хариулав.

Нарангэрэлт “Хэл ам сугалчих гэсэн хэцүү хүүхэд байна” гэж салахын мөн болоод:

-Гурван царст уул хүрэх замыг чи ч мэдэхгүй биз дээ? гэхэд

-Үнэндээ би мэдэхгүй. Манай эндээс цааш явахад үнэхээр хэцүү. Талаар явбал чоно ихтэй, уулаар явбал хад хавцалтай, дундуур явбал шавар ихтэй. Тийм болохоор нарны дээр, насны залуудаа ирсэн замаараа буцвал амь нас, аливаад чинь хэрэгтэй болов уу? гэж зөвлөв.

Нарангэрэлт түүний үгийг үл ойшоож:

-Ах чинь зорьсондоо хүрэлгүй замын голоос буцдаг эр биш. Явахаа явж, туулахаа туулж, хүрэхдээ хүрнэ гэж бардамнанхан өгүүлэхэд нусан жур хүү ер юм санасан шинжгүй:

-За яахав, та өөрөө л мэд. Хоньчин хүүгийн үг хонин чинээ алтнаас үнэтэй байж ч магадгүй гэж хэлээд цааш одохдоо:

-Тал газраар явбал тавиун байж ч магадгүй дээ гэж хэлээд хангинатал дуулж, жингэнэтэл исгэрсээр хониныхоо хойноос яваад өгөв.

Нарангэрэл хэсэг зуур бодлого болж зогссоноо “Энэ муу жаал юу л мэдээ аж” гэж бодоод уулын замаар явахаар шийдэж унасан мориндоо ташуур өглөө. Нар гурав мандтал, сар гурав шингэтэл явсаар байтал хойшоо ч үгүй, урагшаа ч үгүй хадан хясаанд тулж гацав. Ус, гол тэртээ дор толины гэрэл адил гялтганаж, үүл тэхий дундуур нь хөвсөлзөн нүүсэн хадан хясаанаас эргэж гарах газаргүй бөгөөд дөрөв биш дөрвөн зуун алдын цаана, тав биш таван зуун алдын цаана нөгөө уулын орой сүмбэрлэн харагдана. Нарангэрэлт нусгай хүүгийн үгэнд оролгүй бардамнаж уулын замаар явсан ухаан тэнэгтээ харуусан хадан хавцлын ирмэгт хаашаа ч үгүй хашигдан хоёр гурав хоног саатав.

Нэгэн өглөө унасан хүлэг нь үүрсэн өгүүллүүн:

-Сайн хүний үр байтлаа санаагүй яасан эр вэ? Сайхан төрсөн эр байтлаа ухаангүй яасан хүн бэ? Ингээд бид үхэх гээгүй л юм бол эцсийн аргаа бодох хэрэгтэй. Миний сүүлнээс хэдэн ширхэгийг сугалагтун! Хялгасны нэг үзүүрийг өөрөө атга. Нөгөө үзүүрийг бялзуухайдаа зуулган тэртээ уулын орой руу нисэгтүн! гэж хэлэв гэнэ.

Нарангэрэлт мориныхоо хэлсэн ёсоор туг сайхан сүүлнээс нь хэдэн хялгас сугалан нэг үзүүрийг нь өөрөө барьж, нөгөө үзүүрийг нь бялзуухайдаа өгч эсрэг харагдах уулын орой тийш нисэв. Мориных нь сүүлний хялгас сунан сунасаар нөгөө уулын оройд хүрэхэд тэр нь мод болон хувирч, гүүр болон тавигдав. Нарангэрэлт баясан инээв. Бялзуухай нь ч баясан жиргэв гэнэ.

Нарангэрэлт морио хөтлөн дамнуурга гүүрэн дээгүүр явахад салхи гарч унахыг шахахад бялзуухай нь түшин тэнцүүлж явсаар арай гэж нөгөө уулын оройд хүртэл гишгэх газартай, буух замтай болж гэнэ.

Ийнхүү цааш одож, нарыг гурав мандуулж, сарыг гурав шингэтэл явжээ. Тэгтэл

өдөржин яваад туулахын аргагүй өргөн их ой тэр аяараа түймэрт автсан тул явах зам нь бас л мухардаж өдрийг өнжин, сарыг саатан хүлээж, аргаа баран сууж байтал морь нь бас л хүний хэлээр өгүүлрүүн:

-Сайн хүний үр байтлаа санаагүй ясан эр вэ? Сайхан төрсөн эр байтлаа ухаангүй ясан хүн бэ? Бялзуухайн далавчнаас өд сугалагтун! Хоёр суганд минь шигтгэгтүн! Тэгээд олмоо чангалж, дөрөөгөө холбоод эмээлдээ бат сууж, нүдээ тас анигтун. Нүдээ нээ гэхээс нааш нээж болохгүй шүү гэж хэлэв.

Нарангэрэл мориныхоо хэлсэн ёсоор бүгдийг хийлээ. Бор морь нь хэдэнтээ янцгааж хэдэнтээ эргэлдсэнээ агаар цойлон нисэв гэнэ. Ингэж нисэн ниссээр “Нүдээ одоо нээгээрэй” гэхийг бүдэг бадаг сонсож, нүдээ нээвэл аймшигт түймэр ор мөргүй хойно үлдэж, уул тал нь хосолсон, ургамал ус нь жигдэрсэн үзэсгэлэнт сайхан газар ирсэн байж гэнэ.

Нарангэрэл морь, шувуу хоёроо хайрлан биширч, сөгдөн сөхөрч, талархал илэрхийлэв. Ингээд өндөр газар гарч алсын бараа харж суутал алс тэртээ уулын энгэрт голын хөвөөнд гурван өндөр мод байв. Цааш нь лавлан хартал гурван давхар байшин харагдав гэнэ. Нэг дэх давхар нь чулуу, хоёр дахь давхар нь мод, гурав дахь давхар нь шилээр бүтсэн үзэсгэлэнтэй сайхан байшинд хүрч ирвэл алда цагаан сахалтай азай буурал өвгөн угтан гарч ирэв.

-Аян замдаа сайн явж ирэв үү? Ах чинь чамайг мөн ч их хүлээлээ дээ. Унаа морь чин сульдав уу? Учир саад тохиолдов уу? хэмээн дөлгөөн тайвнаар асуугаад дагуулж оров.

Нарангэрэлт гэрээс анх гарснаа, гэнэдэж замд осолдох шахсанаа орос өвгөн Одаад ширхэгчлэн ярьж өнжиж хонон алжаал тайлав. Хамаг явдлыг сонссон Ода толгой сэгсрэн:

-Тэр аюулаас чинь нэн бэрх, тун сүрхий дайсан өмнө чинь тулгарна. Орос ах Вася чинь одоо лав амьд байхгүй байх. Тэр хэрэв амьд бол өдийд лав ирэх болсон. Хар санаат хааныг дарахаар явснаас хойш даруй арван жил өнгөрч байна. Араас нь яваад хэрэггүй боловч нэгэнт зорьсон газраа хүрч ирсэн болохоор алтан шарилыг нь үзээд буцвал зүгээр сэн. Агт сайхан алаг морийг нь хөтлөөд буцвал зүгээр сэн.

Өвгөн ах чинь үхэх өдрийг угтан хүлээж байна. Сайн санааны үзүүрт сүү гэдэг сэн. Муу муухай санаа могойн хорлол гэдэг сэн. Уулын Ода өвгөн би олон зүйлийг үзсэн толгой. Хорвоо дэлхий өргөн боловч хотол түмэн олон боловч сайн нь ч их, муу нь ч их, сайхан нь ч их, муухай нь ч их тоост их хорвоо дээр уг нь сайн нь муугаа дийлж байдаг тавилантайсан гэж боддог юм.

Тэртээ жилийн намар, түйвээн самууны үе. Хар санаат хааны сүүлчийн хүчийг хайрт Вася гурван нөхрийнхөө хамт дөрвүүлэхнээ хиар цохиж явсан өдрийг би яаж мартаж билээ. Сайн бүхэн дийлж дэлгэрэх болтугай, муу муухай бүхэн сөнөж устах болтугай! гэж өсөхөөс өтлөхийг хүртэл хүсэн мөрөөдөж явсан би тэдэнтэй хүч, сэтгэлээ хамтатгасан юм.

Дайсны цэрэг олоон олон, толгойны үс шиг байлаа. Бид тавуулаа, ёстой л оочийн сахал шиг байсан. Алив бэрхийг арга ухаанаар дийлдэг хойно. Замбараагүй олноос зангидсангар шиг тавуулхнаа бид ялж чадсан юм.

Сүүлчийн өдрийн тулалдаан шувтаргандаа ойртож, шунахай тэд амиа алдах гэж байж, амьтан хүнээс дээрэмдсэн алт сувдаа ачаалан ухаан жолоогүй цувж байлаа. Тэгтэл бидэнд золгүй явдал болсон юм гээд тамхиа татан чимээгүй болов.

Өндөр дээд Ода өвгөн өтгөн дарс аягалж, өнгийн идээ таваглаж Нарангэрэлт хүүд хандаж цааш ярив:

-Хар санаат хааны хатан нь шулам байжээ. Бүх цэрэг нь сөнөж дуусахад хаанаасаа салж ард үлдээд харцын хувцсаар хувцаслаад бид хэд дээр уйлж ирсэн юм. Бид ч түүнийг итгэж авсан юм. Тэгээд тэр, шөнө дунд гурван нөхрийг минь дарсаар хөлчүүрүүлж эцэст нь хор өгөөд эрээн могой болж мөлхөж оджээ. Маргааш нь Вася бид хоёр хэрэг явдлыг үзэн гашуудаж, гурван сайн нөхөр, гурван сайн баатраа эцсийн замд нь үдэж энэ уулын энгэрт оршуулсан юм.

Тэр хар эрээн могойг хөөн гүйцэж хэдэн хэсэг цавчин хаяад хээрийн нохойд хувааж өгсөн юм. Вася минь надад ингэж хэллээ:

-Ода дээд өвөө минь, хэлмэгдсэн олныг аварсан ч гэсэн хэрэг зориг минь дутуу байна. Хар санаат хааны хар толгойг аваагүй цагт миний сэтгэл амрахгүй нь. Гэртээ ч би буцаж чадахгүй нь. Би хойноос нь нэхье. Барс мэт барьцалдаж тулалдъя. Арслан мэт алалдан тулалдаъя гэдэг байна. Хорьж би үзлээ. Хамт явъя гэж гуйлаа. Аль алины минь тэр зөвшөөрсөнгүй. Алаг морио унаад явлаа. Тэгээд л ирээгүй. Би хойноос нь явах чадал нэгэнт үгүй болжээ.

Ода өвгөний яриаг онцгой сонирхон сонсож суусан Нарангэрэлт сая л ам нээж:

-Тийм ээ Вася ахын зөв. Би ч бас л тэгж бодож байна. Муу юмны үндсийг таслахгүй бол могойн хор шиг бусдыг хөнөөнө. Би ингээд явах минь. Морь, бие ч амарлаа. Дарсан бол дарсныг нь үзье. Дарагдсан бол тэрний ч үзье гэж босов. Өвгөн Одагийн нүүр нүдэнд баяр түгшүүр хослон:

-Хүү минь жаахан хүлээ. Нас чинь залуу, цус чинь шингэн байна. Хар санаатыг зүглэхдээ хамаагүй явж болохгүй. Миний үгийг сонс. Тэр хааны чимээ орд эндээс тийм ч холгүй.

Эхлээд элсэн цөл бий. Тэр нэг их өргөн бус, дараа нь чулуун ой бий. Түүнийг нэвтэрч болно. Түүний цаана төмөр өргөсөн ширэнгэ бий. Түүнийг нисэж давна. Тэгэхэд хар хааны ордон гэж нэг л том хар уул бий. Уулын хормойгоор үзэсгэлэнт сайхан цэцэг бий. Түүн дээр гишгэж болохгүй. Нэлдээ хорт цэцгүүд юм. Уулын дундуур дан жимс бий. Түүнээс идэж болохгүй. Мөн л цөмөөрөө хор. Уулын оройд туждаа мөс байгаа. Түүнийг гэтлэх нэн бэрх. Ууланд гарах ганцхан зам бий. Тэр замыг чинь миний аягын чинээ алаг хав нохой чамд зааж өгнө. Ууланд чи лавтай гурван хоног мацаж хүрнэ. Уулын оройд чи өдөр гарч болохгүй. Шөнө гараарай. Зам дуусах нэгэн хөтөл дээр чулуу овоо байгаа. Тэнд чи нуугдах хэрэгтэй. Өндөр уулын ар шилээс нэгэн өндөр хүн гарч ирнэ. Тэр хүн бол хар санаат хаан юм. Түүнийг чи үзмэгцээ буудаж болохгүй. Хармагцаа хашгирч болохгүй. Үүрийн харанхуйгаар сүүдэгнэн явсаар өглөө болж нар тусахад гэртээ ирнэ. Хаалга татаж орохынхоо өмнө гурвантаа эргэж харна.

Гурав эргэж хараад нааш эргэхэд нь хоёр далных нь хооронд буудаарай. Хоёр далных нь хооронд эрхий дарам хар мэнгэ бий. Түүнийг л онож чадвал чи дийлнэ. Эс оновол эргэж ирнэ гэж санахын хэрэггүй. Ингээд би чамд өөрийнхөө гараар дархалсан бууг өгье гээд шилэн давхартаа дагуулан оров. Байшин гурван давхар хаалгатай, гурван давхар цоожтой боловч дотор нь гоц гойд юм юу ч байсангүй. Харин галан улаан цэцэгнээс дөлөн дусал нэгэн болор вааранд ганц нэгээр дусаж байх аж. Ода өвгөн чулуун цоожтой гантиг чулуун авдар нээж алтан замагтай, очир алмаасан овоо харатай нэгэн сайхан бууг гаргаж ирээд:

-Тэр дайсныг энэ зэвсэг л дийлж магадгүй. Түүнээс биш нум сумаар яасан ч дийлэхгүй. Миний буу бас зүгээр буу биш. Онох газраа зөв тохируулж чадсан бол гох нь дарагдана. Эс тэгвэл хөдлөхгүй. Миний бие тун их дорджээ. Би чамайг долоон сар хүлээж чадахгүй, долоо хоног л хүлээнэ. Энэ бууг би арван жил хийсэн юм. Хийгээдидийг нь үзэж чадахгүй нь дээ гэж харамсаж байсан юм. Чи азтай, би ч хувьтай хүн юм байна.

Орос ахынхаа шарилыг олоод яс нь махнаасаа мултарсан бол авч ирээд хэрэггүй. Гагцхүү гавлынх нь ясыг авч ирээрэй. Бие цогцос нь муудаагүй бол хав нохой нүүрийг нь долооно. Тэгвэл чи харлаг моринд нь дүүрээд ирээрэй. За ингээд хүү минь яв даа гээд элгэндээ тэврэн санаа алдав. Ихэр татан нулимсаа арчив.

Нарангэрэлт хүү Ода өвгөнтэй салах ёс гүйцэтгээд хав нохойгоо түрүүлүүлэн, эрхийн чинээ бялзуухайгаа орой дээрээ дагуулан исгэж алтанзамагт буугаа үүрч хар санаат хааны зүг явлаа. Уулын хормойн цэцгэнд орж ирээд нүд нь харанхуйлан сохрохыг шахав. Уулын бэлийн жимсэнд орж ирээд ухаан нь балардан унахыг дөхөв. Уулын оройн мөсөнд ороод хөл нь хөшиж, хөшөө болох аядав.

Ингээд Ода өвгөний захисан ёсоор уулын хөтөлд шөнөөр гарч үүрээр харвал Нарангэрэлтээс нэг дахин өндөр хүн, урд хар буу мөрлөн уулын шилээр гарч ирэв.

Нарангэрэлт алтан замагт буугаа ар даланд нь онилон шагайж зэхтэл урт буут, өндөр хүн гэрийнхээ үүдэнд очоод гурвантаа эргэн хараад эргэх агшинд бууныхаа гохыг атгав.

Тэр хүн огло үсрэн эргэж Нарангэрэлтийг буудах гэснээ болив бололтой “Хэн намайг буудсан хүн түргэн хүрч ирнэ үү” гэж өндөр дуугаар нүргэлүүлэн хашгирав.

Нарангэрэлт “За би өнөөх мэнгийг нь оносонгүй. Одоо ч өнгөрчээ. Эх, эцгийн итгэл, эрдэмт өвгөний найдварыг биелүүлж чадсангүй” гэж өөрийгөө зэмлэхдээ үхлээс ч айсангүй. “Би буудсан юм аа” гэж хариу хашгиран бос ирэв. “Наашаа хүрээд ир” гэж дахин дуудсанаа буугаа хол чулуудан хаалганыхаа өмнө лагийн суув. Нарангэрэлт тийн сэтгэл ихэд догдлон шууд явсаар хүрч очив.

Хар санаат хаан аахилж уухилан:

-Энэ газар эндэлгүй хүрч ирэхийг бодоход ч аргагүй л сайн эр юм. Даанч чи намайг гэнэдүүлж дөнгөлөө. Ээжийг минь чи ясныг би мэдсэн. Би ер нь юунаас ч айж яваагүй. Чамайг нааш ирж явааг мэдээд би замд чинь олон саад тавьсан. Чи эрийн зориг, морины сайнаар туулж иржээ. Тэгээд энд нэвтэрч ирэхийг Ода өвгөнөөс өөр хүн мэдэх ёсгүй. Хэрэв чамайг хүрч ирээгүй бол тэр ухаант өгөр толгой бид хоёр цуг үхэх байсан боловч наад буунаас чинь айгаад халдаж чадалгүй өдий хүрсэн. Би чамайг дөнгөвөл дөнгөх л байна. Гэвч хоёр сайн эр нэг дор эрстээд яахав. Миний ээлж болог. Муу юм надаар дуусах болно. Чиний гэнэн, миний нүгэл хоёр нөхөж баршгүй юм. За би үхэх боллоо. Манайхаар ор хэмээн арай чамай босож Нэрэнгэрэлтийг дагуулав. Хар санаат хаан үзэсгэлэн гоё орд харштай аж. Үнэт үс, алт, мөнгө алив бүхэн өрөөстэй, хураалттай байна гэнэ. Хар хаан:

-Хүний хүссэн бүхэн энд бий. Чи юу дуртайгаа ав!

Миний ордон өргөөг эзлэн суусан ч болно гэхэд Нарангэрэлт үл тоомсорлон:

Надад юу ч хэрэггүй. Гагцхүү орос ах Вася минь л хэрэгтэй гэвэл:

-Тэр орос залууг би өөрийнхөө гараар алсан. Харин тэр үгүйлшгүй хурдан харлаг мориг нь би хайрлаад хадгалж байгаа. Миний зандан өргөөнд бий. Зүүн тийшээ гурван хонгил өнгөрөөд баруун тийш эргээд эхний хаалга. Ахын чинь шарил миний шүрэн өргөөнд бий. Доошоо шатаар бууж долоон хаалга өнгөрөөд найм дахь өрөөнд бий. Ах, морь хоёрыгоо авбал түргэн ав. Би үхэх нь, тун ч тэсэхгүй нь, түргэлж үз гэж шаардав.

Нарангэрэлт зүүн тийшээ явж харлаг морийг нь гаргахад морь үүрсэн шилгээв. Доошоо орж орос ахынхаа шарилыг үзвэл огтын янзаараа шинэхэн байх тул хоёр гар дээрээ өргөж авч гарав. Хар хаан сульдсан,тамирдсан дуугаар:

-За чи өөр юу ч авахгүй юм биз дээ? Уулнаас чи түргэн буух хэрэгтэй. Цаг алдвал аюул болно. Хорвоогийн муу бүхэн надаар дуусах гээд яарч байх шиг байна. Нарангэрэлт баатар минь баяртай. Одоо чиний замд юу ч саад болохгүй. Баяртай! Түргэлж үз. Би тун ч тэсэхгүй нь гэлээ. Нарангэрэлт ахынхаа шарилыг харлаг моринд нь дүүрэн уулын оройгоос нисэн бууж холдов. Хойно нь тэнгэр газар нийлэх мэт их чимээ нүргэлэхэд эргэж харвал хар хааны ордон-уул тэсрэн дэлбэрлээ.

Нарангэрэлт айх аюулгүй, шулуухан явсаар уулын орос өвгөн Ода хүрч ирэв. Ода өвгөн Нарангэрэлтийг угтсангүй. Суудаг өргөөнд нь орж ирвэл орон дээрээ мөнх нойрсжээ. Амьд мэндэд нь уулзаж чадаагүйдээ Нарангэрэлт харуусан хагацал, гуниг хослон байтал хажуугийн ширээндээрх захиаг нь олж харав. Захидлыг задлан үзвэл:

“Нарангэрэлт хүү минь, би чамайг тун ч хүлээж чадсангүй. Ертөнцийн жам ийм хойно яая гэхэв. Хэрэв чиний үйлс өлзийтэй бүтэж орос ахын чинь шарил бүтэн байсан бол миний шилэн өрөөнд орж болор ваартай цэцгийн шүүсийг ахынхаа аманд долоо дусаагаарай. Цаашид яахыг өөрсдөө мэднэ биз. Та нар явахдаа манай байшингийн дэргэдэх гурван царс модны дунд талын модонд нэгэн товчлуур бий. Түүнийг дараарай. Вася та хоёрын нөхөрлөлөөр хорвоогийнх үн төрөлхтөн замнах болтугай. Өвгөн Ода нь та нартайгаа үүрд салъя!” гэж бичжээ.

Нарангэрэлт шилэн өрөөнд гүйн орж болор ваартай дуслыг авч ирээд Вася ахынхаа аманд долоо дусаав. Эхлээд нүүрэнд нь туяа татав. Дараа нь бие нь бүлээсч эхлэв. Төдөлгүй хөдөлж эхлэв. Даанч их удалгүй нүдээ нээв. Тэгээд Нарангэрэлтийг харж дуу алдан босч ирж тэврээд “Би яасан их унтаа вэ?” хэмээн гайхахад “Та унтаагүй шүү дээ, үхээд босч байна” гэхэд Вася нээрэнтийм бил үү хэмээн Нарангэрэлтийг тэврэн үнсэж:

-Баярлалаа чамд. Би яамайг л миний хойноос ирэх болов уу? гэж бодсоор явсан юм. Бялзуухай минь хаана байна вэ? Харлаг морь минь хаана байна вэ? Чи үүлэн бороороо ирсэн үү? гэхэд шувуухай нь жигүүр дэлгэж, харлаг, бор морь хоёр нь үүрсэн унгалдан хүрч ирэв.

Тэд бүгдээрээ баярлан мэндэлцгээв. Ингээд нутаг орондоо буцах болж. Ода өвгөний ачийг шагшин шагшсаар гарцгаав. Өвгөний захисан ёсоор гурван өндөр царс модны дунд модонд байсан товчлуурыг дарав. Ода өвгөний сайхан байшин нь газар руу гэнэт шингэж оронд нь алаг цэцэгт ойн сайхан төгөл үүсэв.

Вася, Нарангэрэлт хоёр харлаг, бор хоёр морио унаж, хав, бялзуухай хоёроо авч, алтан замагт буугаа үүрэн нутгийн зүг хөлгийн жолоо залж гэнэ.

Үлгэр ингээд төгсөв. Ухаант дүү нар минь сайн бодоорой ! Орос Монголын ард түмний олон жилийн найрамдлын үлгэр энэ. Өөрөө би бүгдийг зохиогоогүй. Өвөг дээдсийн хэлсэн олон үлгэрийг санаж бичсэн минь энэ бөлгөө. Эрт урьдын цагт гэнэ. Энэ дэлхий дээр Ганаа нэрт хүү өвгөн эцгийнхээ хамт амьдран суудаг байжээ. Эцэг хүү хоёрт эдлэл хөрөнгө гэж юу ч үгүй байжээ. Тэр хоёр ганцхан төмөр сүхтэй гэнэ.

Өвгөн эцэг нь өтлөх насандаа заяасан ганц хүү Ганаагаа дагуулан айлаас айл дамжин модоор юу хэрэгтэй болгоныг хийж амьдардаг байжээ.

Гэтэл нэг өдөр эцгийнх нь бие муудаж, хүүдээ ингэж захив.

-За миний хүү ! Аав чинь одоо үхэх боллоо. Миний хүү биеэ дааж амьдрах хэрэгтэй. Аав нь хүүдээ эд хөрөнгө үлдээж чадсангүй. Ганцхан энэ сүх л миний хүүгийн амьдралын нөхөр болно. Олон түмэн ард түмний хүүгийн амьдралын нөхөр болно. Тэднийгээ чи ямагт түшиж яваарай. Ядарч хэлмэгдсэн алив амьтанд чадлынхаа хирээр тус болж яваарай. Чамд ганцхан дайсан дайралдаж магадгүй. Тэр бол залхуу гэдэг аймшигтай зүйл юм. Залхуу бол хүний амнаас хоолыг нь булааж,хийморь цогийг нь мохоодог зүйл шүү. Биеэ нөөж жаргалыг горилвоос чамд юу ч олдохгүй. Харин чадал оюуныг шавхан хөлсийг дуслуулбаас хүссэн хүсэл биелэгдэн, жаргалын үүд нээгдэнэ.Хүний хоёр гаранд хорин зааны тэнхээ бий. Арван хуруунд арван арслангийн чадал бий. Оюун ухаанд огторгуйн одноос олон эрдэм бий. Хүнд тус болохдоо хөлс шангий нь бүү бодоорой. Өгснийг нь чамлалгүй авч яваарай. Бидний явж байсан энэ зөргийг дагаж яв. Гурван хоног яваад их замтай нийлэх болно. Цааш нэлээд явтал нэгэн тосгон бий. Тэнд чиний нагац Гавар дархан гэж өндөр хөх өвгөн бий. Түүнтэй чи амьдрах болно. Яс махны тасархай нь болохоор нагац чинь чамайг яагаад ч ад үзэхгүй гээд хайрт эцэг нь балчирхан хүүгээ үүрд орхин насан өөд болжээ.

Ганаа хүү нулимсаа хэрэвхураасан бол нуур болохоор уйлж,хайрт эцгээсээ хагацан хоцорчээ. Ингээд хайрт эцгээ нутаглуулж, сүхээ үүрч ойн зөрөг даган явав. Түргэн урсгалт горийнхөвөөнд амарч суутал сандарч тэвдсэн оготнуудын дуу сонсдов. Харваас, оогтнын хэдэн зулзага усанд живэх шаханхөвж явна гэнэ.

Ганаа хүү бушуухан босч бяцхан зулзагануудыг малгайгаараа утган уснаас гаргаж голын эрэг дээр тавихад тэдний заримынх нь амнаас ус годгодон, зарим нэг нь усаа шилгээн, годорхон сүүлээ хөдөлгөн сэтгэл нь амрах шиг болов. Даан их удаагүй байтал эх оготно нь гүйнирж зулзагнуудаа үнэртэж үзээд, Ганаа хүүг хэдэнтээ тойрч, хойд хоёр хөл дээрээ зогсон час, час хийн дуугарах нь “Танд их баярлалаа !” гэж байх шиг санагдав.

Эх оготно зулзагануудаа дагуулан өтгөн өвсөн доогуур шурган алга болов. Ганаа хүү цааш өдөрчийн газар явж,хээр хоноод өглөө эртлэн явж байтал хаданд хөлөө хавчуулсан гөрөөсний бяцхан янзага хар хамраа сарталзуулан, хоёр нүдээ бүлтэлзүүлэн байжээ.

Ганаа хүү өлсөж цангаж явсан боловч өчүүхэн тэр амьтныг өрөвдөхийн ихээр өрөвдөж, сүхээ хол орхин ойртож очвол янзага “Амь авар, утсан чинээ улаан гол минь таны л гарт байна” гэх шиг бөмбөлзөн байв. Хүү түүнд аяархан дөхөж очоод нурууг нь илж, хүзүүг нь маажиж тайвшруулаад, эцэст нь хад чулууг нурааж, хоёр хөлийг нь суллав. Янзаганы турьханхөл нь шалбарч цус асгарч байх тул агь, ганга шарханд нь нээж, бүсээ цуулан урж хоёр хөлийг нь боож өгөв.

-“Бяцхан янзага минь ижил сүрэг чинь хаана байна вэ? эхээ чи олох уу? Эсвэл надтай цуг явах уу? Эзэнгүй ойд чи эндэх вий, эвий минь” гэж хүнтэй ярьж байгаа юм шиг хүүрнэн өгүүлэхэд янзага Ганаа хүүг үнэрлэн эрхэлж өвчүү хүзүүгээ маажуулаад цовоо хөөрхнөөр дэгдэн цовхорч дүүлсээр одов.

Ганаа хүү сүхээ авч, бас л цаашаа одов. Хад бартаатай уулыг давах гэж, хамаг хүчээ барж дуусаад арай ядан амарч суутал элээ, хэрээ эвсэн нэг юм руу дайрах болж гэнэ. Хүү сандран ухасхийж “Хэнийг ингэж түйвээнэ вэ?” гэж тэр газар яарч очвол хүрэн могойн өндгийг тэд булаахаар шийдэж учир зүггүй дайрч байна гэнэ. Өндгөө хамгаалсан могой орох гарахаа олж ядан эвхрэн матиран сандарч байв.

Ганаа учрыг ойлгоод “Жигүүрийн хүчинд та нар дээрэлхэж, зүгээр байсан эд нарыг зовоох гэж, яасан шунахай амьтад вэ?” хэмээн амандаа үглэсээр элээ, хэрээ хоёрыг эргэж ирэхгүй болтол нь хөөж хэд алхсанаа санаа нь бас л зовж модны хэдэн гишүү цавчин жижигхэн урц босгов.

Айх аюул нь холдсон хүрэн могой тайвширч аймаар нүдээ зөөлрүүлэн Ганааг харан хэвтэв. Өндгөнд нь урц босгосонд учиргүй баярлан цогнолзов. Ганаа хүү могойг “баяртай” хэмээн далласаар цааш замдаа оров.

Ойн зөрөг тодорч дардан замтай нийлэв. Дардан замыг дагатал суурин тосгон харагдав. “Ашгүй, олонтой газар ирлээ. Ажил хийнэ дээ” гэж амарч хэсэг суув. Тэгтэл тосгоны наагуур урсах өргөн голыг даган өөд уруугаа олон хүн бужигналдав гэнэ. “Хэн нэг нь усанд унаж, хэрэг явдал болсон шиг байна. Миний тус хэрэгтэй байж магадгүй” гэж бодоод Ганаа хүү тийшээ очвол түшмэд, ноёд бухимдан, түмэн албат нь мэгдэн хар сахалт өндөр ноён хамгийг захиранхашгирах нь:

-Хааны гүнжийн алтан самыг харанхуй болохоос нааш олохгүй бол бүгдийг чинь энэ голд живүүлнэ ! гэнэ. Алтан самыг эрсэн усчин олон эрчүүл өргөн гол руу үсчин аль гүн рүү нь шумбана. Эрэг дээр хүлээсэн хүмүүс уснаас гарч ирсэн хүний гар руу гөлрөн ширтэнэ. Үд аль хэдийнээ өнгөрч нар хэвийжээ. Хар сахалт ноён хамаг олныг зандчивч дахиад орох тэнхэлтэй хүн даанч тэдэнд байсангүй.

Сүх барьсан Ганаа хүү олны өмнө гарч ирэв. Чухам хаахнуур эрэхийг цугларсан

олноос асуув.

-Бяцхан хүү минь хэрэггүй. Бидний заяа орхиж. Хааны гүнжийн алтан сам харц бидэнд түйтгэр боллоо гэж өвгөн настангууд хорив.

Хар сахалт харин Ганаад дөхөж ирээд.:

-Эрийг бүү бас, далайг бүү янд гэдэг. Сам олоод ирдэг юм бол шан харамж хайрлахгүй. Хаан өөрөө амласан юм шүү, харай дүү минь ус руу! Азаа үз! хэмээн ятгав.

-Ганаа хүү олзонд болж ус руу зүтгэсэнгүй, олон ардын амийг бодож:

-Сүхийг минь харж байгаарай” гэхэд хар сахалт даажигнан:

-Миний муу төмөр сүх битгий хэл, гүнжийн алтан сам ус руу унаад яая гэж байхад, наад муу чинь үнэтэй юм биш, наанаа л хачихвал болоо биз гэж зандрал.

Ганаа хүү зориггоо чангалан биеэ хөвчилж их голын эрэг дээрээс эгц доошоо шумбан оров. Хурсан олон дуу алдацгааж “Хаанаас гараад ирэв ээ? Энэ хүү хатан зоригтой сайн эр юм. Нас нь даанч бага юм. Уснаас амьд гарах болов уу? Сам олох нь ч яамай. Өөрөө л амьд гараасай. Бидний төлөө энэ хүү амиа лав бүрэлгэв бололтой. Ус даанч гүнзгий гэж дуу шуу болов.

Хүү огт бараагүй. Нар уулын толгойд шүргэв. Ганаа хүү усандоогуур чулуу болгоныг бараг эргүүлж үзэв. Замар бүрийг ширхэглэж нэгжив. Өргөн тэр голын өөд уруу гурвантаа ингэж самнаад эцэс сүүлд эргүүлэг устай эргэнд шурган оров.

Хорвоогийн нар жамаараа шингэх цаг нь болов. Уулын цаагуур нарны тал алга болов. Уймарсан олон сандарч уйлан, хайлан шуугилдав. “хааны зарлиг хууль” гэж хар сахалт уурсан, хүн бүгдийн хүзүүнд хүнд чулуу дүүжлэв.

Усны эргүүлэг даанч хүчтэй. Ухаан алдам шуугиж байв. Ганаа хүү чадлаа шавхан эргүүлэг усыг нэвтэрч элсэн тохойг самардаж үзвэл өнөө сам нь гарт баригдав. Шүдээ зуун дээш зүтгэв.

Гэрэлт нарны гуравны нэг уулын цаанаас цухуйж байхад гартаа сам барьсан Ганаа хүү эрэг тийш ойртов. Усанд хаягдахаар заагдсан олон хүн уулга алдан зэрэг хашгирав.

Хар сахалт ноён:

-Харж байна уу, гайхлыг? Олоод ирлээ шүү. Одоо та нар чөлөөтэй гэж тас тас инээнэ. Хүнд чулууг хүзүүнээсээ мултлан хүмүүс тайтгаран санаа амрав.

Хааны гүнжийн самыг олсондоо хар сахалт баярлавч, хайр шангий нь алдана гэхээс харуусах сэтгэл төрнө. “Олны өмнө энэ хүүг хөхүүлж сайшаах нь зүйтэй. Ордонд очихоос өмнө гэж шүрэн бугуйвч шагнаа. Цугларсан олон тарсанхойно сүхийг нь ус руу шидчихье. Сүхэндээ тун хайртай юм билээ. Сүхнийхээ хойноос энэ заавал орно. Тамирдаж сульдсан энэ хүү дахиад уснаас гарахгүй. Хааны ордонд би ганцаараа очно. Хаан надад охиноо ч өгч магадгүй” гэж хар санаа агуулав.

Ганаа хүү уснаас ганхан дайван гарч ирэв. Хүмүүс түүнийг угтан гар дээрээ өргөв. Хар сахалт самыг нь авч эргүүлэн тойруулж шалгав. Тэгснээ тэр Ганааг булааж аваад хоёр гар дээрээ өргөн:

-Аяа, чи ёстой баатар эр. Чиний харьшгүй хүчтэй хатан бат зоригтойг чинь олон бүгдээр үзэж биширлээ. Чи хаан эзэнд минь хамгийн хүндтэй гавьяа байгуулж хайр хишгийг нь хүртэх хувьтай боллоо. Би чамд юуны өмнө шүрэн бугуйвчаа бэлэглэж гэж хуурамч магтаал өргөөд хурсан олныг тармагц:

-Хааны шагнал одоохон хүртэх чамд энэ муу төмөр сүх юуны хэрэг байх вэ? хэмээн хуйлран эргэлдэх их усун эргүүлэг тийш хайр эцгийнх нь үлдээсэн сүхийг нь чулуудав.

Хүү хар сахалтын гараас мулт үсрэн хайрт эцгийнхээ сүхний хойноос ус руу үсрэв. Хар сахалтын бах нь ханаж өвөртөө хийсэн алтан саама дахин дахин дарж үзсээр хааны ордны хаалгаар хар хурдаараа давхин оров.

Хаан хатан хоёр охиноо дагуулан хар сахалтыг угтав. Агсам хөлгийнхөө амыг омогтой татаж, алтан самыг барьсаар мориноос буухад:

-Зориг самбаатай чиний алдрыг магтъя. Үүнээс хойш чи миний баруун гарын түшмэл боллоо гэж хаан зарлиг болгон өгүүлэв.

-Охины алтан самыг олж ирсэн чамд олон албатаар шагнаа гэж хатан нэмж хариулав.

-Баатар таны алдар бадраг. Баярлалаа ! гэж хааны гүнж саама аваад хөөрөн баяссар ордондоо оров.

-Хаана төдхөн шадруудаа цуглуулж найрын ширээ засав. Хамгийн эхэнд хар сахалт, хаантай зэрэгцэн суугаад өөрөө л самыг олсон юм шиг аагтай дарсыгхөнтөрч байлаа. Өрөөл бусад нь атаархан шивэр авир ярилцаж байлаа.

Хүний хүчээр олсон магтаалдаа ташуурсан ноён ордонд тэгж наргиж байхад

хөөрхий хүү Ганаа үхэл, амьдралтай өрсөлдөж байлаа.

Гүнзгий голын чимээгүй боловч аймшигтай, харанхуй эргийн доогуур хайрт сүхээ эрсээр байв. Нойтон элс, нялцгай замаг эсвэл хайрга чулуу тааралдана. Хоолгүй удаан явсан хүүгийн ходоод гэдэс нь тасрах шахаж, урсах устай хүчээ сорьсон хүүгийн тамир алдарч ухаан санаа нь орон гаран байв.

Нар хэдийнээ шингэсэн тул ус бас харанхуй, мөч өнгөрөх бүр хүүгийн бие хүндэрч байв. Тэгтэл гэрэлт загас хүрч ирээд Ганааг хэд тойрсноо “миний хойноос яв” гэх шиг сүүлээ хүчтэй шарваад өмнө нь орж хөдлөв. Ганаа араас нь дагаж сэлж алгуур урагшлав. Төдий хол явалгүй гүн эргүүлэг чиглэв. Гэрэлт загас түрүүлэн тэр зүг рүү оров. Араас нь Ганаа зориглож эцсийн хүчээ шавхав.

Эргүүлгийн дор сүх нь хэвтэж байхыг хараад Ганаагийн сэтгэл баясаж алжаал ядралаа мартаж, шалав түргэн шүүрч аваад эргэв. Хар ус шуугин хүрхрэн эргэлдэнэ. Хамаг хүч гарган Ганаа гарахыг хичээв. Толгой нь эргэн, дотор нь харанхуйлавч сүхээ чанга атгаж эргүүлэг уснаас гарах гэж эрдэм чадлаа үзэв. Ухаан нь балартаж үхэдхийн унах агшинд усан дотроос үзэсгэлэнт сайхан ордон урган гарч харагдав.

Тэр ордны очир алмаасан хаалгаар найман гоё хатан гарч Ганаа руу алгуурхан ойртож ирээд гар дээрээ аван өргөх шиг болов. Нэг л мэдэхэд, хамаг бие нь тас хөрч, дагжин чичрэв. Нүдээ нээгээд харвал одот тэнгэр дээр нь харагдав. Мод шигхөшсөн гараа арай чамай хөдөлгөж тэмтэрвэл гарт нь газар шороо тааралдав. Дахин цааш тэмтэрвэл сүх нь бас баригдав.”Ашгүй сүх минь байна. Би уснаас амьд гарч дээ” гэж бүдэг бадаг ухаарав.

Тэгтэл хүмүүсийн яриа алсад сонсогдов. “Та минь ээ ! Наашир. Нөгөөх хүү чинь энд хаягдчихсан байна. Амьд байна. Халуун цай... Дулаан дээл” гэх яриаг сонсоод Ганаа “Би бас л солиорч байна. Ер нь би эргүүлэгнээс яаж гарсан юм бол. Тэр гэрэлт загас тусалсан байж магадгүй. Энэ сонсогдож байгаа яриа жинхэнэ хүний яриа мөн байгаасай” гэж бодов.

Ганаа энэ удаа солиорсонгүй, жинхэнэ хүмүүс, хамгийн сайхан сэтгэлтэй хүмүүс түүнд туслахаар иржээ. ооч сахал, шодон гээг хоёр нь бараг тэнцүү хатингар боловч чийрэг өндөр хөх өвгөн бүхнээс түрүүлэн:

-Бидний аминд орсон ачтай хүү хэмээн Ганаагийн аманд халуун цай цутгаж дулаан дээлэнд ороож тэврэн гэрийн зүг явав. Түүний араас хүмүүс эрсэн эрдэнээ олсон юм шиг л их л баяртай дагалдав.

Ганааг усны эргээс гэртээ авчирсан хөх өвгөн бол эцгийн нь зааж захиж явуулсан нагац ах дархан Гавар нь байжээ. Энэ цагаас эхлэн ганаахүү нагац ахындаа амьдарч өвгөн Гавар төмрийн дарх хийнэ. Ганаа мужаан хийнэ.

Нэг өдөр Гавар нагац нь хот руу орж ирээд:

-Хааных охиндоо ордон бариулах гэнэ. Хамаг урчуудад зар тараасан байна. Хамгийн сайхан ордон барьсан хүнд хаан охиноо өгөх гэнэ гэхэд:

-Ямар ордон юм бол? гэж Ганаа асуув.

-Ямар ордох гэх вэ дээ? Барьсан ордонг охин нь өөрөө сонгох юм гэнэ. Охины санаанд нийцсэн ордон барьж босгоно гэдэг хэцүү дээ. Чухам л уран гартай ухаан төгс хүнд л охиноо өгнө гэсэн санаа юм даа гэж Гавар өвгөн сахлаа имэрч ганц нэгээр тамхиа нэрэв.

-Би оролдоод үзвэл чадахгүй болов уу? гэж бүлтгэрхэн нүдээ эргэлдүүлэн зээ нь нагац руугаа ширтэв. Өвгөн Гавар инээмсэглэж ганаагийн толгойг илж:

-Эр хүний дотор эмээлтэй хазаарт морь багтдаг гэж, санадаг л санаа. Гэхдээ манай хааны охины санаанд нийцүүлнэ гэдэг маш бэрх. Хэрвээ чи эцгийнхээ хийж бүтээдэг эрдмийг үнэхээр өвлөж чадсан бол ч бас учир бий гээд өвгөн баахан бодлогошров.

-Үзээд алдахад яадаг юм бэ? гэж Ганаа зориглон хэлэв.

-За тэгвэл тэг. Эхлээд чи модоо сонгоно. Эцэст нь хэв янзыг нь бодно. Дараа нь барьж эхэлнэ. Би чамд тусална гэж өвгөн ам өгөв.

Ганаа ихэд баярлаж төмөр сүхээ авч ой модыг чиглэв. Өвгөн сэтгэл хөөрч хоол хүнсийг нь үүрүүлэв. Ганаа ууланд гараад нарс, царс, хуж, улиас гээд мод болгоныг шинжиж, сонжин гурван сар явав. Ганц нэгээр нь цуглуулсаар зүүн тэрэг мод бэлтгэв.

Энэ үед ноёд, баядууд олон олон мужаан дархчуулыг өрсөлдөн цуглуулж сайхан ордон босгож, хааны гүнжийг авахаар орондоо амрах завгүй олон тийшээ давхилдаж байв.

Хөрөнгө зоорио хайрлалгүй нэг нь нөгөөгөө давах гэж гоё ганган ордонг хэд хэдээр нь босгов. Түрүүлж барьсан заримыг нь сүүлд барьсантай харьцуулж “Цонх нь буруу байрлаж, дээвэр нь намхан болж, тэднийх шалыг нь царсаар хийж, эднийх хаалгыг нь алтаар эмжиж” гэж хурааж засч барьсаар жил болов.

хааны товолсон хоног хариугүй тулж ирэв. Ганаа хүү энэ үед модоо л дөнгөж цуглуулж байлаа. гагцхүү өвгөн нагац нь л түүнд тусална. “Ямар ордон барих вэ? гэж хоёул баахан зөвлөлдөөд эцэс сүүлд нь баяд ноёдын барьсанордыг очиж үзэв. Алтан мөнгөн чимэгтэй, янз янзын ордыг үзээд “Бид хоёрын санааны гарз, биеийн зовлон юм. Тэдний барьсан ордон гэдэг үнэхээрийн үзэсгэлэнтэй юм” гэж өвгөн ах нь зориг мохов. Ганаа хүү сэтгэлээр унан газар хэвтэнгунигт автав.”Харьж гэртээ буцъя” гэсэн нагацынхаа үгэнд орохгүй эзгүй хээр ойн чөлөөнд үлдэн хэвтэж

хоцров.

Ганаа хүү ингэж хэвтсээр нам унтжээ. Үүрийн гэгээ манхайх цагаар сэрж өндийвөл өмнө нь нэгэн гөрөөс зогсож байна гэнэ. Ганаа нүдээ арчин гайханхарав. гөрөөс улам ойртон дэргэд нь тулж зогсоод хүний хэлээр ярив.

-“Амрыг айлтгая ачит хүү минь. Намайг та таньж байна уу?” Байц хаданд хавчуулагдан амь эрсдэх гэж байхад ач тусмаа үзүүлсэн ариун сэтгэлийг чинь мартаагүй. Одоо танд туслах миний ээлж болсон. Ордон босгох хэрэгтэй болж бүтэн жил зүтгэснийг чинь мэдсэн. Санаж бодсон зүйл чинь саадгүй гэнэт бүтнэ. Надад та итгээрэй. Хааны товосон өдрийн урд шөнө эндээ хоёул уулзъя. Гүнжийн сэтгэл татах ордонг түргэн барихад сүх чинь танд тусална” гэж гөрөөс хэлээд гэнэт алга болов.

Гайхсан Ганаа яаран босч эргэн тойрныг ажиглав. “Зүүд нойрны үзэгдэл үү, ид шидийн явдал уу? Эцгээ оршуулаад явж байхдаа хаданд хөлөө хавчуулсан янзгыг гаргаж тавьсан минь үнэн. Эцгий минь үлдээсэн эцсийн энэ хөрөнгө төмөр сүх минь ч тусална л даа” гэж Ганаа ганцаар ярив.

Хааны товлосон өдөр маргааш болно. Ойн тэр чөлөөнд ноёд баядууд хөлхөлдөн бусдыг дайчилж бариулсан ордон шилтгээнээ магтан өөрсдөө л босгочихсон юм шиг омог бардан байцгаахдаа хамаг юм нь з адгай, ганаахүүг шоолон “Хараач энэ мууг нусаа татаж чадахгүй байж ордон бүтээх санаатай” гэж хэлэхийн муугаар хэлж байв. Эмс охид нь шивнэлдэн ичгүүр сонжуур болгож байв.

“Үнэхээр ч тийм дээ” гэж Ганаа баахан гутарсан ч шөнө болохыг хүлээхээр шүлэг нойрондоо умбав.

Анхилам агаартай ойн чөлөөнд амтат нойронд автаж байхад хангинуур сүхний дуу ойд цууриатсаар байх шиг, хаана ч байхгүй ордон шилтгээн сүндэрлэж ч байх шиг...

Ганаа гэнэт сэрвэл шөнө хэдийнээ өнгөрчээ. Үүрийн харанхуй өвч нөмөрч, юу ч харагдахгүй сандаргав. Сүхээ аваад босох гэтэл улайс халсан сүх гарыг нь түлтэл хайрав. Урагшаа алхам хөдлөх гэтэл өмнө нь хаалга тээглэв. “Юу билээ?” хэмээн эргэлзэж дороо азнатал юу юугүй үүр цайж гэгээ гэрэл тусав. Гэтэл шижир алтан дээвэртэй, үнэт эрдэнийн цонхтой гайхамшигт сайханордон гарцаагүй өмнө нь харагдав.

Гайхах, баярлах зэрэгцэн гараа чанга атгавал алганы цэврүү нь хагаран ус асгарч хорсов. Гэвч түүнийг тоолгүй ордны хаалгаар оров. Өрөө тасалгаагаар нь явж нүдээ баястал сонирхов. Өрөө тасалгаагаар нь явж нүдээ баястал сонирхов. Есөн эрдэнээр урласны зэсэн тасалгаанд ортол таг нь нээлттэй зандан авдар тосож өмнөөс нь ирэв.

Авдар дотор байгааг авч үзвэл Ганаад таарах ганган хувцас, чамин эдлэл өвч бүрэн байв.

Муу хувцсаа тайлж, сайхан хувцсыг өмсөж сүхээ аван гарав. Ордны хаалган дээр үлгэрийн юм шиг хар морь эмээл хазаартайгаа дүүхэлзэнэ гэнэ.

Алс тэртээ замаар хаан заларч айсуй. Албат иргэд нь дагалдан сүр бараатай наашилна. Адаг сүүлд нь харин өвгөн нагац нь бараадан явааг олж танив.

Ганаа моринд мордтол гар дахь сүх нь хувирч очир алмаасан шигтгээтэй ум зандан ташуурб олов. Хар морь гүйдэлгүй жороо аж. Тавьж нэг үзэв, татаж нэг зогсоов. Тэгснээ хаан эзнээ угтахаар хазаарын жолоог залав.

Айсуй олон зогтусаж амрыг айлтган мэхийв. Хаан ихэд гайхаж, хатан ахайтан талимаарч, охин нь сүйхнээс цухуйн ойн цэцэг шиг найгав.

Хаан эзний тэргүүлсэн олны цуваа хөвөрсөөр ойн чөлөөнд барьсан орд харшийг сонирхов. Гүнжийн сэтгэлд таацвал тавих улаан алчуурыг хүмүүс ширтэв.

Барьсан ордонгуудыг үзэж дууссан ч хааны охин алчуураа хэнийхэд ч тавьсангүйд хаан эцгээс эхлээд хамаг ноёд түшмэд сэтгэл нь гонсойж зүс нь барайв.

-Эзэн дээд хаан минь, эндээс тун ч холгүй газар миний барьсан ордон бий. Үзэж ажаамуу! гэж Ганаа хүү зориглон хэлээд хар мориныхоо жолоог залав.

Хааны цуваа араас нь хөдлөв. Ганаа хүүгийнордонд хүрч ирэхэд охин тэрэгнээсээ үсрэн гарав. Гараа алдлан байж, баясан хэдэнтээ бүжиглээд гал улаан алчуурыг ордны үүдэн дэлгэв.

Морьтой нь мориноосоо бууж ширтэв, морьгүй нь өвдөг дээрээ сөхөрч ширтэв гэнэ. Хар сахалт ноён л “Адтай муу зулбасгыг дээ ! Алтан самыг чи л олж ирсэн. Алтан ордонг чи л барьж байдаг. Хааны гүнж чинийх болж байдаг!” гэж бодон х орсолдоо шатах шахаж байв гэнэ. Хаан Ганаа хүүд баяр хүргээд хуримын өдрийг зарлав гэнэ. Хурсан олон хөгжиж найр наадамд бэлтгэв гэнэ.

Маргааш хурим болно гэж байтал хааны охин Сарангоо гэнэт алга болж уй гашуу хоромхон зуурд тарж, уйтгар гуниг бүхнийг нөмрөв. Хаан хатан хоёр хайлж, нулимсаа барах шахав. “Миний охиныг олсон хүн л хань нь болох болтугай. Хаан ширээгээ би өгч,хамаг олныг захируулна” гэж арай ядан айлтгал тараав. Ард олон эрэлд мордов.

Ганаа хүү ч гал, ус харших мэт сэтгэлээр унаж,итгэл нь мөхөөд хуучин муу хувцсаа өмсөж, төмөр сүхээ аваад Сарангоо охиныг эрэхээр явав.

Хар сахалт ноён л хамагхэргийн эзэн байв. Найр болохын өмнөх шөнө юмсан. Хамаг олон унтаж амрах цагаар, хааны шадар түшмэлийн хувьд, ордны бүх түлхүүрээс охины өрөөнийхийг олж аваад, муур шиг сэм гэтэж, могой шиг чимээгүй мөлхсөөр, гүнж сайхан зүдэнд умбаж, зугаацаж байх үед аманд нь алчуур чихэж, алаг нүдийг дарж боогоод авч явсныг хэн ч мэдсэнгүй. Хар сахалт, Сарангоо охиныг сэм тохирч хэлэлцсэн ёсоор доод тивийн Болор эвэрт хааны хүү долоон голт эрээн Хэдгэнэ гэгчид далан тэрэг алтаар худалджээ.

Эрэлд явсан улс эргэж ирсээр байв. Сайхан төрсөн Сарангоо гүнжийн сураг чимээг хэн ч гаргасангүй. Хаан хатан хоёр уйлсаар л байв. Хамаг олон шаналсаар л байв.

Ганаа хүү Сарангоо гүнжийг эрж гучин хоног явж эрлийн үзүүр мухардаад, эцэст нэгэн чулуун дээр амарч суув. Эргэн тойрныг харж гөлрөв. Гэтэл зүүн өмнөх өндөр ууланд том агуй харлан үзэгдэв. Тэр зүг рүү яаран алхамв. Агуйн өмнө тулж очвол Сарангоо гүнжийн алчуур нь хэвтэж байна гэнэ. Агуй руу доошилсон замаар явбал, шив шинэхэн хэдэн дусал цус дуссан байна гэнэ. Ганаа хүү цусыг шинжиж, гарынхаа алга дээр тавьж үнэртвэл яах аргагүй Сарангоо бүсгүйн сайхан үнэр үнэртэж гэнэ.

Ганаа хүү агуйд шурган орвол адал явдалтай учирч гэнэ. Уул нь дандаа доошоо харсан, мод нь мөн л доошоо, ус нь харин дээшээ урссан үнэхээр сонин газар гэнэ. Ганаа тэнгэрээс зүүгдэх мэт модноос мод дамжин, хаднаас хад дамжин үсэрч наадан цаашлав. Гар алдаж, хөл хальтарвал, хөлгүй их далай юм уу, хөх цэнхэр тэнгэр ч юм уу, доор нь юу ч үгүй тул нэн аймашигтай гэнэ.

Хэдэн махчин бүргэд өөхий, хөлөө дээшээ харуулан нисч ирээд Ганаагийн хөлнөөс нь шүүрэх гэж зовоов. Ганаа модноос хөлөөрөө дүүжлэн байж гараа суллаад махчин бүргэдүүдийн далавчийг сүхээрээ тас цохиж намнав.

Цаашаа нэлээд явтал толгойноос нь ирвэс идэх гэж ногоон нүдээ бүлтийлгэж, араа шүдээ ярзайлгаж архирч, хүрхэрч ирэхэд гараа алдан осолдохыг шахав. Ганц мөчир дээр тээглэн амь аврагдав.

Хайрт сүх нь хань болж халдах араатанг хөнөөв. Ингэж зүдэрч, тэгж зовж явтал хаанаас ч юм бүү мэд, үлгэрвэлэл хэдгэнэ шиг эрээн биетэй, зүйрлэвэл бар шиг тэнхээтэй бахим том эр Ганаа хүүг базан аваад хаана ч юм, нэгэн газар авч ирж, тансаг сайхан ордонд түлхэн оруулж гэнэ.

Нүд гялбам танхимын эхэнд гэрэл бадарсан түшлэгт сандалд сахал нь хэдэн алд урт бөгөөд цасан цагаан толгойдоо болор хоёр эвэртэй хаан заларч суув. Долоон голт эрээн Хэдгэнэ ихэд хилэгнэн.

”Энэ муу чигчийн чинээ хүү Сарангоо авхайн хойноос ирсэн байхгүй юу. Би уур хүрч золтой л тастаад хаячихсангүй хэмээн хүнгэнэсэн хөндий дуугаар өгүүлэхэд “Жижигхэн амьтанд эр бяр гаргавал нэрийн гутамшиг. Тэр газраас энэ газар хүрч ирснийг бодоход эрхийдээ эрчтэй, чигчийндээ чадалтай эр байгаа биз ээ. юу ч гэсэн

эрдэм чадлыг нь сорьж үзье” гэж эрээн Хэдгэнэ хүүдээ Болор эвэрт хэлээд Ганаа хүүд хандаж “Хэрэв чи Сарангоо авхайг авах гэж ирсэн бол гурав хоногийн хугацаатай гурван бооц хийе. Өнөө шөнөдөө чи будаа ялгана. Эс чадвал толгойг чинь авна” гэж хэлээд мөсөн таягаараа зангав.

Хэдгэнэ хүүгийн хамт хэдэн зар нар Ганаа хүүг аваачиж нэг байшинд оруулаад:

-Энэ байшинд шар, цагаан будааг хийж хольсон юм. Өглөө болоход шар, цагаанаар ганцыг ч үлдээхгүйгээр ялгах ёстой. Хэрэв ялгаагүй буюу нэг ширхэгийг боловч нөгөөд нь хольсон бол маргааш чи толгойгүй болно” гэж Эрээн Хэдгэнэ хэлээд хаалгыг гаднаас нь цоожлов.

Ганаа хүү түүнийг ширхэг, ширхэгээр нь ялгаж эхлэв. Хичнээн хурдан ялгасан ч будаа гэдэг арвин, ядрах гэдэг жигтэйхэн.

Нэг мэдэхэд Ганаа хүү нам унтсан байлаа. Хамрын нүхийг нь ямар нэгэн юм сэрвэгнүүлэхэд цочин сэрэв. Нэгэн том хулгана өмнө нь цөмцойн суугаад:

-Ачит Ганаа хүү минь аварч биднийгээ өршөөснөө андуугүй сайн санаарай. Миний хэдэн зулзага тэгэхэд усанд сүйдэх шахсан юм. Та хэрэв туслаагүй бол тэд минь живэх байсан. Таны хайрта Сарангоо энд байгаа нь үнэн. Түүнийг долоон голт эрээн Хэдгэнэ нэрт хүн хүч түрэмгийлэн авчирч хүндэтгэлийнхээ ордонд цоожилсон. Одоо би танд туслах цаг болсон. Та юу ч гэсэн алжаасан биеэ амрааж унтах хэрэгтэй ! гэж хүний хэлээр хэлэв.

-Баярлалаа, хулгана минь. Тэгэхдээ би унтаж болохгүй. Өглөө болохоос өмнө энэ будааг ялгах ёстой. Тэгэхгүй бол болор эвэрт хаан өглөө болоход толгойг минь авна гэсэн гэхэд:

-Ганаа минь санаа зоволтгүй. Та ганцаараа энэ будааг ялгаж чадахгүй. Хулгана бид олуулаа. Хоромхон зуур ялгаж чадна. Ганаа хүү та амар. Тун их ядарсан байна гэж хулгана өрөвдөж хэлэв.

Ганаа хүү баярлаж байшингийн нэгэн буланд очиж унтав. Гэнэт сэрэхэд өглөө болжээ. Гадна хаалганы цоож дуугаран Долоон голт эрээн Хэдгэнэ орж ирэв. Тэр ялгаж овоолсон будааг хараад толгой сэгсрэн гайхаж:

-Ийм сүрхий хүн байдгийг үзэх нь бүү хэл дуулаагүй юм байна гэж дуу алдан гайхаад түргэн эргэж одов.

Дахиад л Ганааг Болор эвэртийнд аваачив.

-Цагаан, шар будааг чамаас өөр ялгах хүн үгүй биз. Эрдэнэ чадлыг чинь үзмээр санагдлаа. Элс гурил хоёрыг ялгуулна гэлээ.

Ингээд Ганааг бас л элс гурил холилдсон том байшин руу түлхэж хаалгыг нь цоожлов. Ганаа хүү уйтгарлаж “Одоо ч би өнгөрлөө. Гурил, элс хоёрыг ялгаж яасан ч дийлэхгүй” гэж бодон уйлан хайлан суув. Шөнө дундын үед хулганууд дахин ирж:

-Сайхан сэтгэлт ах минь санаа сэтгэлээ зовоогоод хэрэггүй. Унтаж сайхан амар. Ялгаж бид дөнгөнө. Алив ах минь амар. Ажилдаа бид оръё! гэлээ.

Ганаа хүү баярлан “Тийм жаахан тусыг ийм ихээр хариулах... хачин аа!” гэж бодоод байшингийн буланд хэвтэв. Өглөө сэрвэл өмнө нь элс, гурил хоёр эгэлгүй ялгарсан байв гэнэ.

Яг цагтаа Эрээн Хэдгэнэ нэрт “Одоо чи ч толгойгоо өгөхөөс аргагүй байх аа” гэсээр орж ирэв гэнэ. Гэвч Ганаа хүү элс, гурил хоёрыг гайхалтай сайхан ялгасныг үзээд:

-Ай чи хэцүү амьтан байна. Амьд явахад ийм юмыг үзэх нь бүү хэл, дуулсан ч удаа байхгүй. Хаан аавдаа хэлэх минь гэж харайн гарч одов.

Гурав дахь өдрийн өглөө Болор эвэрт дуудав.

-Элс, угил ялгаж чаддаг эрдэм ухааныг чинь үзлээ. Гурав дахь сорилыг давж чадвал гарцаагүй чамд Сарангоог чинь өгнө. Хэрэв эс чадвал бид толгойг чинь авахгүй. Бүх насаараа чи тэндээ байх болно гэв.

Долоо голт эрээн Хэдгэнэ нэрт хэсэг зарцын хамт Ганааг авч явлаа. Хаалга, цонхгүй тугалган байшинд хийж, оройг гаднаас нь цутгав. Түүний гадуур төмөр байшин давхарлаж хаалгыг нь гаднаас нь гагнав. Түүний гадуур ширмэн байшин барьж цоорхойг нь гаднаас нь ширээв.

-Эрдэмт сүрхий эр минь ингэж чи өнгөрөх нь тэр. Амьдаараа тугалга, төмөр, ширмэн авсанд орох чинь энэ. Сарангоо сайхан бүсгүй чинь миний болох нь энэ! гэж Эрээн Хэдгэнэ нэрт бардамнан, басамжлах нь бүдэг бадаг сонсогдож байв.

Ганаа хүү нэгэн хоногийг уйлж өнгөрөөв. Дараахь хоногийг дуулж өнгөрөв. Гуравдахь хоногт нь унтав. Тэгтэл шүлэг нойрон дунд нь шаржигнах чимээ гарах шиг болоход Ганаа хүн “Хэн бэ? Юу вэ?” гэж хашгирав.

-Би байна. Ганаа хүү минь харанхуй болохоор би таныг, та намайг харахгүй байна. Элээ, хэрээ хоёр өндөг рүү минь эрчлэн дайрч байхад биднийг та аварснаа санаж байна уу. Би тэр могой чинь байна. Таныг олох гэж тун ч их зовлоо. Ашгүй харин хулганууд хэл боллоо гэж сөөнгөдүү дуугаар ярив.

-Аа, одоо санаж байна. Та нар тэгээд намайг мартаагүй хэрэг үү? Энэ ширмэн, төмөр, тугалган гурван давхар байшинг чи яаж нэвтэрч орж ирэв ээ? гэж Ганаа хүү

гайхан асуухад:

-Элээ, хэрээний аюулын өөдөөс таны сайхан сэтгэл нэвтэрч, эргээд ирэх вий дээ гэж халхивч хаалт барьж өгсөн ачлал чинь юутай ч зүйрлэшгүй байхад энэ тугалга, төмөр ширмийг нэвтлэх нь бидэнд юу ч биш шүү дээ гэж хариулснаа:

-За та сонс. Бид таныг эндээс гаргана. Өнөө шөнөжингөө гулсан мөлхөн хөрөөднө гэхэд:

-Та нарын хайрс тэсэх болов уу? гэж Ганаа хүү асуухад:

-Санаа зовох юмгүй. Бид өөрийг чинь багтахаар нүхэлж чадна. Тайван сайхан амрагтун гэлээ.

Ийм үгийг сонсоод Ганаа хүүгийн сэтгэл уужрав. Эргэж гарах найдвартай юм шиг санагджээ.

-Шөнө өнгөрч өглөө болов. Өдөр өнгөрч үдэш болов. Харуй, бүрий болж харанхуй эхлэх үеэр том хүрэн могой түлхүүр зуусаар орж ирэв.

-Өнөө шөнө бид таныг гаргаж лавтай чадна. Үзэсгэлэн гоо гүнжийн байгаа өрөөний түлхүүр энэ Та хоёрыг авахаар алтан эвэрт гөрөөс ирэхээд бидэнтэй тохирсон.

Болор эвэрт хааныг ямаан хорхой болгоё. Долоон голт Хэдгэнэ нэрийг жинхэнэ хэдгэнэ болгоё. Идтэй тийм “рашаан” надад байна. Энэ бүхнийг танд би амлая гэхэд:

-Баярлаа! Насан туршдаа мартахын аргагүй тусалсныг чинь үеийн үед дурсъя. Үр удамдаа захъя гэж Ганаа хүү торомгорхон нүднээсээ том том нулимс дуслуулав.

-Уйлаад хэрэггүй Ганаа минь. Урьд шөнө би явж авга ахаасаа тусламж гуйсан. Аварга тэр ах минь ач хүчээ нэмэрлэе гэсэн. Одоо мөдхөн хүрч ирнэ. Айж та болохгүй шүү гэж аргадангуй дуугаар өгүүлэв.

Гурван давхар байшин дэнжигнэн хөдөлж алд урт хэл, араас нь аварга том могойн толгой орж ирэв. Хүрэн могой баярлан хүүгийн өвөр дээм мурилзав. Аварга могой толгойгоо хэд цогнолзуулснаа буцаад цааш гарав. Ганаа байтугай заан гармаар уйтан нүх үлдэв гэнэ.

Хүрэн могой төдхөн хүүг дагуулан гарав. Хүрэн могой алгуур мурилзсаар долоон голт эрээн Хэдгэнэ нэртийн өргөөндорж унтаж байгаа түүн дээр хэдэн дусал дусаав. Тэр үхэр хэдгэнэ болон ордон дотуураа дүгнэнэв. Хоёул цаашаа явж Болор эвэртийнд оров. Ганааг ормогц тэр давхийн босч ирэв.

-Би чиний булшнаас амьд мэнд гарч ирлээ. Одоо би Сарангоог авч болно биз дээ? гэхэд урт сахлаа намируулан байж, уур омгоо давхцуулан байж:

-Чам шиг идтэй амьтан хаана ч ердөө байхгүй нь. Бушуу тэр эмээ авч манай эндээс зайл! гээд буурал сахлаа ширвэн цас мөсөөр шидлэв.

-Болоогүй нөхөр минь. Сүхээ би энд орхихгүй. Миний сүх хаана байна ? гэж эр зоригтой асуухад, зоослон матирч байгаа хүрэн могойг хараад Болор эвэртийн зориг,хилэн нь намдаж:

-Тэр муу сүхээр яах юм бэ? Оронд нь үүнийг ав гэж алтан сүх шидэв. Авсангүй, мөнгөн сүх шийдэв. Авсангүй. Болор сүх шидэв. Авсангүй. Эцэст төмөр сүхийг нь өгөв.

Ганаа хүү төмөр сүхээ авмагц хүрэн могой “рашаан” шүршив. Хаан ямаан хорхой болж далавчлав.

Ганаа хүү могойгоо дагаж цааш явсаар Сарангоо сайхан гүнжийн байгаа өрөөний үүдийг нээв. Сарангоо гүнжийн хацар, мөр нь хүрэн эрээн,хамар амнаас нь цус урсчээ.

Ганаа ухасхийн түүний дэргэд очив. Могой авиран дэрэн дээр нь гарав. Сарангоо гүнжийн хамаг бие нь хөрчээ. Зүрхийг нь чагнаж үзвэл зүрх нь таг зогсчээ.

Айж, харууссан Ганаа “Одоо яах билээ?” гэсэн шиг могой тийш харав. Могойн байсан газар шүрэн толгойт мөнгөн болжмор жигүүрээ хэдэнтээ хөдөлгөснөө амнаасаа гурван сувдыг гүнжийн аманд унагав.

Гүнж нүдээ нээлээ. Ганааг хараад уйлав. Тэгснээ тэврэн авав. Тэр хоёр ордноос гарав. Хэдгэнэ, ямаар хорхой хоёр тэр хоёрыг тойрон дүгнэв.

Мөнгөн болжмор үлдэн хөөж мань хоёрыг хавьтуулсангүй. Хаалгаар тэднийг гарч ирэхэд алтан эвэрт гөрөөс, ардаа сүйх тэрэгтэй, агаарт дүүлэн зогсоно гэнэ. Гүнж, Ганаа хоёр сүйх тэргэнд суув.

Алтан эвэрт гөрөөс агаарт дүүлэн нисэв. Сайхан сүйх тэрэг нь сансарт хөөрөн гарав. Сарангоо, Ганаа хоёр бие биесийг чанга тэврэн, сайхан алаг нүдээ хоёул зөөлхөн аньж, цохилох зүрхэндээ хайр жаргал бялхуулж явахдаа урт зам туулсныг алтан эвэрт гөрөөс сүйхнээс салсныгтэгээд хоёулаа хаан эцгийнхээ ордны үүдэнд ирж зогссоныг мэдсэнгүй, анзаарсангүй гэнэ.

Хайр охиноо алдаад гурван жил болсон хаан, хатан хоёр баярт мэдээ ирэв. Ордон даяар бужигнаж бөөн шуугиан дэгдэв. Хаан аав,хатан ээжийн халуун нулимс хацар дээр нь дусахад хоёул гэнэт сэргэв.

Хөөрөн баярласан хаан төдхөн найр зарлав. Үзэсгэлэн гоо гүнж хуримын хувцсаа

өмсөв. Ойн чөлөөний сайханордонд олон хүн цугларав. Хаан хатан хоёр дундаа Ганаа, Сарангоо хоёрыг суулгав. Хааны баруун гар талд Ганаагийн Гавар нагац суугаад нүднээсээ баярын нулимс мэлмэрүүлэн нүүрэнд нь гэрэл туяарч байв.

Хатны зүүн гарт хар сахалт ноён суужээ. Хуран цугларсан олныг хэдгэнэ, ямаан хорхой хоёр ирж үймүүлэв. Энэ үед бас шүрэн толгойт мөнгөн болжмор ирж, Ганаагийн мөрөн дээр сууснаа найрын эхний дугараа эхлэхэд хар сахалт ноёны толгой дээр буутал Хар сахалт тэрхэн зуур, хар батгана болж хувирав. Батгана, хэдгэнэ, ямаан хорхойг хүмүүс хөөж зайлуулав.

Ганаа хүү төмөр сүхээ өргөн хөдөлмөрийн алдрыг дуулав. Хүн болгонд нэг нэг төмөр сүх бэлэглэв. Түүнээс хойш хүмүүс хэзээ ч алтан сүх хэрэглэсэнгүй. Үрээс үрд залган, үеэс үе дамжин төмөр сүх хүний хүчит зэвсэг болж одоо хүрсэн нь энэ байжээ.

Эрт урьдын цагт энэ явдал болсон юм гэнэ билээ.

Нэгэн ноён байж гэнэ. Түүний Мичид марал гэнэ. Тэр хаан туурга нэвт туяатай, тунгалаг улаан хацартай, гэр нэвт туяатай, гэрэлт улаан хацартай, гишгэсэн газраас нь навч цэцэг дэлгэрч, инээмсэглэн харахад нь наран саран мандах лугаа адил бүхнийг баясгасан үнэхээр үзэсгэлэнтэй сайхан төрсөн нэгэн охинтой юмсанжээ.

Хааны тэр охиныг Мөнгөнсаран гэж нэрлэдэг ажээ. Мөнгөнсаран нэрт охин хөлд орж, хэл сурсан цагаас эхлэн адуучин Асралтын Хасар гэгч хүүтэй тоглон дасч үерхсээр арван найман насыг хүрчээ.

Мөнгөнсаран Хасар хоёр бие биендээ туйлаас хайртай тул өчүүхэн ч холдохыг хүсдэггүй байжээ. Ноён эцэг энэ байдалд эрс дургүйцэж адуучин Асралтыг алс газар нүүлгэхээр болжээ. Аргагүйн эрхэнд салж нүүх болсон охин хүү хоёр хагацаж ядан салахдаа, нэг нэгэндээ дурсгал солилцжээ.

Арван тавны сар агаарт мандсан шөнө, мяралзан урсах голын хөвөөнд сууж Мөнгөнсаран охин:

-За Хасар минь, чи бид хоёр мөд уулзаж чадахгүй боллоо. Чи бид хоёрын уулзах эсэхийг эцэг л мэдэх болно. Гэхдээ чи бид хоёр бие биеэсээ мартаж өсгүй. Хэзээ нэгэн цагт уулзаж магадгүй. Тэр үед бид хоёр бие биенээ танихгүй том болсон байх биз. Аз болж амьд уулзвал гээд алиалан тоглож өссөн алтан, мөнгөн шагайгаа гаргаж, Хасарт алтан шагайгаа өгөөд:

-Үүнийг чи ав. Би мөнгөн шагайг нь авъя. Чи миний алтан шагайг сар бүрийн арван тавны сарны гэрэлд харж байгаарай. Тэр цагт хэрэв би сайн явбал алтан өнгө нь гялалзан гэрэл цацарна. Надад ямар нэг золгүй явдал болох бол төмөр шагай болно. Тэгээд хожим нь уулзахдаа хоёулаа энэ хоёр шагайгаар тэмдэг хийж уулзъя гэж

хэлэв. Хасар түүнийг баярлан аваад:

-Аав чинь алтан шагайгаа яасан бэ? гэж асуувал чи юу гэх вэ?

-Усан унагачихаад ослонгүй л гэж хэлье.

-Чамд их баярлалаа. Чин сэтгэлээсээ баярлалаа! гээд бяцхан морин хуур хөгжим гаргаж:

-Миний аав бол адуучин хүн. Танай ай түмэн адууг малласаар нас нь өтөлж, нуруу нь бөгтийлөө. Эцсийн эцэст энэ нутгаас нүүж хол нутагт хөөгдөж явлаа. Чи сайхан дуулдаг болохоор хөгжим хэрэгтэй гэж аав минь арван жил урлаж, ээж минь дөрвөн жил хээлсэн энэ хуур хөгжмийг чамд бэлэглэе. Энэ бол ганц минийх ч биш, ээж аав бид гурвын бэлэг юм. Энэ хуур хөгжимд орохгүй ая, дуугарахгүй дуу авиа гэж байхгүй. Хуурын утсанд хөвч нь хүрмэгц хүссэн аялгуу яруусан эгшиглэх болно гэж Хасар Мөнгөнсаранд хуур хөгжмөө өгөв.

Тэгээд тэр хоёр нар мандаж цэцэг цомирлогоо дэлгэх хүртэл хагацан ядан сууцгааж хоёр тийшээ салж явав. Адуучин Асралтынхыг нүүснээс хойш Мөнгөнсаран охин ид шидийнтэр хуур хөгжмийг гэгэлзүүлэнхэн хуурдаж уянгын сайхандууг уйлтал, хайлтал дуулдаг болжээ.

Тэр сайхан дуу хөгжмийг нь бүргэд шувуу нисэж явснаа агаарт тогтон сонсож, хун шувууд халуун орондоо буцахаа мартан чагнаж, дархан хүн далайж байсан алхаа буулгахаа мартан сонсож, нар саран шингэхээ саатан сонсдог авай.

Адуучин Асралтынхныг нүүгээд даан их удаагүй байтал Мөнгөнсаран охин хөл хүнд болжээ. Ноён эцэг нь “Адгийн муу Асралтын Хасараас л боллоо” гэж уурлан бухимдах боловч охиндоо туйлаас хайртай тул яаж ч чадсангүй. Гэтэл Мөнгөнсаран амаржих цаг ойртох тутам бие нь мууджээ. Хол ойроос эмч отчийг цуглуулсан боловч хэн нь ч тус болсонгүй. Ингээд хаврын нэгэн орой Мөнгөнсаран бүсгүй нас барав.

Ноён хатнаас эхлээд, харц албат цөмөөр уйлан хайлан гашуудаж гэнэ. Ухаан санаагаа алдаж гэнэ. Нар хиртэн уулын цагаар орж гэнэ. Нарс модод навчаа шидлэн унагаж гашуудаж гэнэ.

Ингээд ноён эцэг хайр охиноо шороонд булж бунхалъя гэсэн ч “Алтан сайхан цогцос нь дээр нь хар шороо хаяад яахав” гэж хайрлажээ. Өндөр модонд өлгөө гэсэн ч “Үнэт ариун цогцсыг нь үүрд дүүжлээд яахав” гэж өрөвджээ.

Тэгээд эцэст нь мэргэн арга олж алтандотортой төмөр авдранд хийж арвин далай зорих их гол тавихаар шийджээ. Ноён охиныхоо цогцсыг хамгийн гоёор хувцаслаж авдарлаад, хамт түүнтэй хуур хөгжим, мөнгөн шагай хоёрыг нь хийж:

-Миний охин мөрөн голыг дамжиж хөвсөөр, их уст далайд хүрээд авдар сав нь зад

үсэрч, агаарт зулзгаа дагуулсан хүн болон нистүгэй. Тэгээд аз заяагүй аав ээждээ жилдээ нэг л удаа жигүүрлэнхэн ирэх болтугай гэж хоёр нүднээсээ хорголын чинээ нулимс унаган охиныхоо шарилыг ургахын улаан нарнаар ус ихт мөрөнд тавьжээ. Авдартай шарил аажмаар хөвөн хөвсөөр, алслан холдов.

Их мөрний хөвөөнөө хотны хэдэн богтой, унааны ганц морьтой эмгэн өвгөн хоёр айл болон амьдарч, аж төрөх суудаг байжээ. Өвгөн мөрний хөвөө даган яндан буурал морио унаж хол ойрыг сонирхон явтал алс тэртээгээс авдартай юм хөвөн айсууг хараад гэрийн зүг байдаг чадлаараа хурдлав. Өсөхөөс аваад өтөл насыг хүртэл өвгөнөө ингэж яарч явахыг хараагүй эмгэн нь ихэд сандарч өвгөнөө тосон очоод:

-Юу болов? Айх аюул ирээ юу? Адгуу хэрэг гараа юу? хэмээн асуухад өвгөн нь их л баяртайгаар:

-Юу болохыг мэдээгүй ээ. Энэ мөрөн дагаж нэгэн авдартай юм айсуу. Дээд тэнгэр өршөөж буян хишиг хайрласан ч юм уу? Хоосон авдар лав байх ёсгүй. Хоёулаа гаргаж авахыг бодъё гэхэд:

-Ээ дээ юу л бол доо. Эд хөрөнгө ч яваа юм бил үү? Эсвэл ад чөтгөр ч хийж аргаа барахдаа усанд тавиа юм билүү гэж эмгэн нь баахан тээнэгэлзэв.

Эцэст нь тэр хоёр авдартай юмыг татаж авахаар шийдэж аргамж дээс бэлтгэж өвгөн нь усанд сэлэн орж гэнэ. Эмгэн нь аргамжныхаа нэг үзүүрээс барьж үлдэж гэнэ.

нэн ч их удалгүй авдартай юм хөвж ирж гэнэ. Өвгөн барьж авах гээд чадалгүй ус самардаж гэнэ. Дахиад хоёноос нь гүйцэж очоод дараад авсан чинь хөмөрч гэнэ. Энэ байдлыг харж зогссон эмгэн нь ихэд айж, усны тэртээ эрэг дээрээс:

-Хүүе чи минь болиоч дээ. Наад авдар дотор чинь лав амьтай голтой аюулт амьтан байх шиг байна шүү. Орхиод бушуухан гараад ирээч ээ ! гэж хашгирахыг өвгөн огтхон ч сонссонгүй, авдартай юмтай хөөцөлдсөөр байж арайхийн нэг барьж авч гэнэ.

Татлага уяагаар баглаж аваад эмгэн нь голын эргээс татаж, өвгөн нь араас нь түлхэж нар шингэх алдад авдартай юмыг гаргаж гэнэ. Хоёул авдрыг тойрон чихээ тавьж чагнаж гэнэ. Эцэст өвгөн ам нээж:

-Ээ дээ, чи бид хоёрт эзэн тэнгэр их юм хайрлах шиг боллоо.

-Чухам аа, чухам. хүнд гэдэг нь чулуу шиг юм . Гурил байвал норчихсон болов уу? гэж эмгэн инээмсэглэхэд өвгөн усаа шавхарч:

-Энэ дотор лав эрдэнийн чулуу юм уу, алт, мөнгө байгаа байх. Авдар нь хичнээн гоё юм бэ? Тааруухан юмыг ч энэ дотор таглаж хийнэ гэж ч байхгүй дээ гэж сэтгэл догдлон өгүүлээд түрдэг тэргээ авчирч авдартай юмаа аяархан гэгч тавьж гэртээ

авч ирж гэнэ. Төмөр авдрын цүү, цуургыг тэгээд тун ч болгоомжтой онгойлгож гэнэ. Эхлээд эрдэнийн сайхан чулуугаар чимэглэсэн эхнэр хүний өмсгөл гарч байна.

-Эс хэлээ бил үү? гэж өвгөн ихэд баярлаж гэнэ. Дараа нь зүйл зүйлийн торго дурдан, боодол боодлоор гарч гэнэ.

-Ээ дээ мөн азтай юм аа гэж эмгэн нь хөөрөн баясаж гэнэ. Цааш нь дахин уудалтал хуур хөгжим гарч гэнэ. Уран сайхан хийцтэй тэр хуурыг эмгэн өвгөн хоёр гар гараа дамжуулан гайхан, гайхан үзэж гэнэ.

Дахиад доош нь уудалснаа өвгөний царай барайж гэнэ. Эмгэний царай хувирч гэнэ. Эмгэн өвгөн хоёр бие биеэ харж хэсэг зуур гайхширснаа авдранд байгаа шарилыг арайхийн гаргаж ирж гэнэ. Үхдэл хэдий боловч үзэсгэлэнт тэр сайхан бүсгүйг хараад “Ийм сайхан амьтан, ингэж залуугаараа эндэх гэж !” хэмээн уйлж гэнэ. Өвгөн жаал сэхээ ороод өнгийж бүсгүйг ширтэж байснаа зулайг нь дарж, судсыг нь барьж, зүрхийг нь чангаж үзэв гэнэ. Тэгснээ өвгөн, эмгэндээ хандаж:

-Авдраа чи одоохон уудал. Ганц ширхэг шинэ тэвнэ бий. Бушуухан гаргаад ир гэж хэлээд зүрхээ цохилуулан, амьсгалаа давхцуулан яарав.

Эмгэн нь өвгөнийхөө хэлсэн ёсоор хар авдраа уудалж, хамаг юмаа санаачин үймүүлж хичээнгүйлж боосон тэвнийг гаргав. Өвгөн бүсгүйн нуруу руу тэвнээр хатгамагц эхлээд хамаг бие нь бүлээсч хацарт нь цус буумагц нярай хүүхдийн дуу гэрт часхийн дуугарав.

Эмгэн өвгөн хоёр үдшийн бүрийгээс өглөөний нартай золготол борви бохисхийлгүй шамдсаар нэг сэхэл авбал сайхан бүсгүй нүдээ нээн инээмсэглэж гэнэ. Төрсөнхөөрхөн хүүн тайван сайхан нойрсож гэнэ.

Эмгэн өвгөн хоёр энэ л яваа насандаа ийм сайхан үртэй болно гэж зүүдлээчгүй болохоор хөл нь бараг газар хүрэлгүй, хөгшин насаа орхин залуу болцгоосон шиг баяртай байцгаав.

Мөнгөнсаран тэр нэгэн өдөр хайр булаасанх онгорхон хүүгээ өвөр дээрээ суулган хөхүүлж суутал өвгөн хүрч ирээд дэргэд нь суув. Учир явдлыг нэгд нэгэнгүй хөөрөлдөв.

-Та намайг яагаад амилуулснаа ярьж өгөөч гэж бүсгүй гуйдаг л гуйлтаа давтав. Өвгөн тамхиа нэрж сэтгэл нь нэг л тавгүй өндөлзөж босмоор болсноо дахиад л суув.

-Үнэн учрыг ярь даа өвөө минь. Миний хойноос хэн ч ирэхгүй. Би буцаад гэр рүүгээ хэзээ ч явахгүй. Ачит таныхаа охин болж амар суух болно. Та намайг явчих байх гэж тун ч сэжигтэй байх бололтой хэмээн Мөнгөнсаран учирлан гуйв. Өвгөн өгүүллрүүн:

-Эмгэн бид хоёр энэ мөрний захад насаа барж яваа улс. Бид хоёрт эд хөрөнгө

байгаагүй ч гэсэн эвтэй найртай сайхан амьдарсаар өдий хүрлээ. Гэвч бид хоёрт голомт залгах үр заяасангүй. Гэтэл чи ирж... гээд нулимсаа арчив.

-Аав минь, та битгий уйл, учир явдлыг ярь даа гэж Мөнгөнсаран хүүхэн хацарт нь хацраа нааж, х айрт хүүгээ өвөр дээр нь суулгав. Эмгэн ирж тэдэндээ идээ, цайгаа аягалав.

-Чи бол ноёны охин. Чамайг тэд үхлээ гэж бодож. Бодохоос ч аргагүй байжээ. Яагаад гэвэл чамайг амаржих гэж байтал хөдөлж байсан хүү чинь эх чинийхээ голыг атгачихжээ. Тэгээд чи ч ухаан алдаж хүү чинь ч гарсангүй. Ингээд чамайг нас барсанд тооцон энэ авдарт хийж урсгажээ. Авдарнаас чамайг анх гарахад амьтай хүний байдал илт юм шиг санагдахад, энэ чухам юунаас болов гэж олон дахин бодож бодож хүүгийн чинь атгасан гарыг тавиулбал чи ч амьд, хүү чинь ч амьд гармаар санагдаж урт тэвнээр хатгасанд та хоёрын аль алиных нь амь аврагдаж ийм сайханюм болох нь энэ дээ гэж өвгөн яриагаа дуусгав.

Мөнгөнсаран бүсгүйн бие сайхан тэнхэрч, алаг хонгор хүү нь дэгэж дэрвэн торниж, тэр дөрөв аз жаргалтайяа сайхан амьдарч гэнэ. Мөнгөнсаран хааяа хуур хөгжмөө уянгалуулан татаж дуу юугаа дуулбал ус мөрөн урсгалаа зогсоон чагна, тэнгэрийн үүл нүүдэллэхээ болино сонсдог болой.

“Ай даа ийм сайхан төрсөн, ид шидийн энэ сайхан дуу хөгжим юу л болдог бол доо” гэж эмгэн өвгөн хоёр сэм сэмхэн шивнэлдэх боловч сайхан дуунд нь өөрсдөө уяранхан байдаг байв гэнэ.

Салхи сэнсрэн, навчис сэрчигнэсэн нэгэн өдөр алс тэр тээгээс урт цуваа наашилсаар наашилсаар хүрч ирлээ. Эхлээд засуул замчид, араас нь хөтөч, оточ хөврөн, алтан сүйх тэрэг, ард нь үй түмэн бараа бологсод явна гэнэ.

Өвгөн гаднаа гарч саравчлан хараад:

-Манай хаан заларч явна. Зулай дээрх зуслангаасаа нүүж, нахиу дээрх намаржаандаа заларч явах шиг байна гэхэд эмгэн нь мөрний гарам чиглэн хувинтай сүү, цацал барин угтав. Гэтэл цас уулын цагаан сахалт хаан өвгөний гэрийг чиглэн ирэв гэнэ. Өвгөн эмгэн хоёр ч хөл алдан угтаж гэнэ. Цас уулын Цагаан сахалт хаан өвгөний бяцхан гэрт морилон орж ирээд:

-Хаан би өтөл боллоо. Тэр газраас энэ газрыг зорьж ирсэнхэрэг бол танай охин хүү хоёрыг гуйж явна. Голомт залгаж төр түшиг үр эрж явтал танайд тэр ерөөлт хүмүүн байна гэж дуулав. Хаан эзний зарлиг буулгах гэж ирсэнгүй. Халуун сэтгэлээ нээн гуйж ирлээ гэхэд өвгөн эмгэн хоёр зөв харж инээж, буруу харж уйлан охин хүү хоёроо аргагүйн эрхэнд өгч явуулжээ. Хэлд орж хөлд ороогүй боловч бяцхан хөөрхөн хүү үргэлж барьж эрхэлж байдаг мөнгөн шагайгаа өвгөн өөд сарвайхад өвгөн шагайг нь авч авдар дээрээ тавьж тахив.

Хаан явахдаа:

-Өвгөн эмгэн та хоёрт үнэн сэтгэлээсээ баярлалаа. Ач тусыг чинь үүрд санан дурсаж анд болон нөхөрлөе.

Миний хойноос нүүж очоорой. Эд хөрөнгө, эрх дархыг эдлүүлнэ гэж буурал тэргүүнээ гудайлган гудайлган талархал илэрхийлэв.

Урт цуваа хөврөн хөврөн холдов гэнэ. Асралтын хүү Хасар нэг удаа Мөнгөнсарангийнхаа өгсөн алтан шагайг гаргаж үзвэл алтан сайхан өнгө нь ал хэдийнээ арилаад зэвэнд идэгдэж хөх төмөр болсон байж гэнэ. Тэгээд Хасар хүү гэртээ ирж аав ээждээ хамар учраа хэлээд аян замд гарч гэнэ.

Хасар явсаар хааныд ирсэн боловч хар уйтгар нөмөрсний дээр хавьтуулж хэн ч ойртуулсангүй. Хаашаа явахаяа гайхаж цөхөн байтал хааны шивэчин сайхан сэтгэлт нэгэн хүүхэн ирж:

-Хасар минь чи энд удаан байж огт болохгүй. Эндээс бушуухан зайл. Мөнгөнсаран чинь нас бармагц төмөр авдарт хийж мөрөн голд урсгасан. Одоо чи түүнийг хэзээ ч олохгүй гэж хэлэв. Хасар уйлан, хайлан гашуудсаар их уст мөрнийг уруудан явжээ. Ингэж явсаар мөрний хөвөөнд буй ганц гэр айлд хүрч иржээ. Тэднийд өвгөн эмгэнхоёроос өөр хэн ч байсангүй.

Морь, биеэ амрааж тэднийд байж байтал хоймрын авдар дээр нь Мөнгөнсаран бүсгүйн мөнгөн шагай байхыг олж харжээ. Хасар хүү шагайг хараад хамаг бие нь халуу оргин байж сууж чадахаа байв. Энэ байдлыг ажиласан эмгэн:

-Хүү минь чи яав? Бие чинь зүгээр үү? гэж асуужээ.

Хасар энэ сайхан сэтгэлт хоёр хөгшнөөс үнэнээ нуугаад яах юм билээ гэж бодоод хамаг учраа тайлбарлаж өврөөсөө алтаншагайгаа гаргаж иржээ.

Өвгөн эмгэнхоёр Мөнгөнсаранг хэрхэн олсон, тэгээд Цаст уулын цагаан сахалт хаан үрээ болгож авч явсан тухай эхнээс эцсийг хүртэл тодорхой ярьж өгөөд Мөнгөнсарангийн араас очих зам, хүрэх газрыг тодорхой зааж өгчээ.

Хасар ингээд Цаст уулын цагаан сахалт хааных руу зорин одож гэнэ. Очих замдаа нэгэнхот айлд буувал “Цаст уулын цагаан сахалт хаан үзэсгэлэн гоо өргөмөл охиноо эрд өгөх гэнэ. Тэгэхдээ дөрвөн зүг найман зовхисын сайн эр, морь хоёрыг цуглуулж их наадам хийж, эр чадалтай эрдэм ухаантай хүнд охиноо өгч хаан ширээгээ залгуулах юм гэнэ” гэсэн мэдээг олж сонсчээ.

Эрийн чадал байвч сайн морь байхгүй, эрхий мэргэний оньч байвч сайн нум сум байхгүй яадаг билээ гэж Хасар хүү гайхшран тэвдэвч цаст уулын Цагаан сахалт хааныхыг зорин явжээ. Хасар явах замдаа нэгэн айлд орвол өндөр дээд настай

өвгөн эмгэн хоёр байж гэнэ. Өвгөн,Хасараас хэрэг зоригийг нь олж сонсоод:

-Ай чи сайны сайн эр шиг байна. Тэгэхлээр чамд би нум сум бэлэглэе. Миний өгөх нумыгтатаж л чадвал хүрэх газар лавтай хүрнэ. Харваа эхэлтэл хэнд ч харуулж болохгүй шүү гэж хэлээд алд дэлэм урт даргай шар нум сумыг өгч гэнэ.

Хасар баярлахын ихээр баярлаж цааш явжээ. Гэтэл олон мянган хонь хариулсан жаал хүүтэй уулзаж гэнэ. Хасар, балчир хүү гэж басамжилсангүй байдал явдлаа түүнд ярьж гэнэ.

Хасарын зорилгыг сонсож мэдсэн жаал хүү:

-Би танд тус болохыг хичээе. МИний аав ноёны адуун сүргийг малладаг юм. Эрхбиш танд, түрүүлж цойлохгүй ч гэсэн түмэн агтын тоосонд дарагдчихааргүй нэг унаа өгөх байх. Маргааш өглөө эндээ уулзъя гэж хэлж гэнэ.

Хасар хээр хонож өвгөний өгсөн алд дэлэм урт шар нум, сумыг эвшээлгэж үзэж гэнэ. Онилж хэд тааруулж гэнэ. Ингээд үүр цайж нар мандаад өглөө болсон хойно хоньчин хүү хонио бэлчээсээр ирэхдээ үс даахиндаа баригдсан өчүүхэн муу бор даага хөтөлж ирж гэнэ. Хасар, бор даагыг хараад анхандаа голсон боловч:

-Энэ даагыг даага гэж бүү бодоорой. Аав хэлэхдээ “Гарааны газраас гарахдаа хоёр шуудай элс ганзгалж гараарай. Замын тэхий дунд ороход нэг шуудай элсээ ханзалж асгаарай. Барианы газар ойртож ирэх үед бас нэгийгээ ханзалж асгаарай” гэж захисан шүү. Таны хүссэн бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай гээд хоньчин хүү одов гэнэ.

Хасар цааш явсаар Цаст уулын Цагаан сахалт хааныд хүрч ирэхэд газар газрын хурдтай морьд, чадалтай эрчүүд, цугларч, гэр майхан багширсан сүр бараа ихтэй байна гэнэ. Хасар цугларсан олныг хэсүүчлэн явсаар эцэст хааны ордон хаана байдгийг сураглаж гэнэ. Даахьтай бор даагатай, уранхай муу хувцастай хүүг тоож дуугарах хүн огт олдсонгүй гэнэ. Тэгтэл ашгүй бас нэгэн ядуулаг охин дайралдаж:

-Хэрэг зориг юунд вэ? Хэт нутаг хаана вэ? гэж асуухад Хасар:

-Хэрэг зориг хааны наадамд ирсэний юм.Хэт нутаг нар гурав шингэтэл яваад хүрэхээргүй газар. Асралт өвгөний хүү Хасар гэдэг би байна. Найр наадам хэзээ эхлэх юм бол? гэж асууж гэнэ.

-Найр наадам маргааш эхэлнэ. Эхлээд бөх барилдана. Дараа нь сур харвана. Хамгийн сүүлд морь уралдах юм гэнэ билээ гэж бүсгүй хариулж гэнэ.

-Та хаана, юу хийж амьдардаг хү бэ? гэж Хасар асуухад:

-Би хааны охин Мөнгөнсарангийн аягачин хүүхэн байна. Мөнгөнсаран ахайтан намайг явж наадамчин олныг сонирхоод ир ! гэж явуулсан юм гэж гэнэ. Хасарын

цээжинд нар гийх мэт болж баярлан:

-Та надад нэг тус болооч ! гэж гуйж гэнэ.

-Юу юм бол? Би чадах бол танд туслахыг бодъё гэж бүсгүй өгүүлж гэнэ.Хасар алтан шагайгаа гаргаж:

-Та үүнийг ахайтандаа аваачаад өгчихгүй юу? гэхэд

-Энэ төмөр шагайг уу? Ахайтан үүнийг чинь яаж тоох юм бэ? гэж учир зүггүй инээж гэнэ. Асралт аргаа олж ядан.

-Зүгээр ээ, аваачаад л өгчих. Ахайтан чинь заавал авах ёстой юм гэж гуйсаар арай гэж аягачин бүсгүйд өгчээ. Хасар бас:

-Би тантай дахиад яаж уулзах вэ? гэж бүсгүйгээс асуухад:

-Би тун ч завгүй байдаг юм. Зав гарвал гурав хоноод яг эндээ өдийд уулзъя гэж хэлээд явжээ.

Цаст уулын цагаан сахалт хааны зарласаних наадам эхэлж гэнэ. Бөх гурван сар барилдах гэнэ. Сур гурван сар харвах гэнэ. Морь гурван сарын газраас уралдах гэнэ. Наадам эхэлсэн боловч Хасарыг хэн ч тоож харсангүй гэнэ.

-Одоо яадаг юм билээ? гэж явж байтал шодон гэээгтэй урт сахалтай өндөр хөх өвгөн ирж:

-Хасар гэдэг хүү чи мөн үү? гэж асууж гэнэ.

-Тиймээ. Би Хасар байна гэхэд өвгөн, том бааданд боосон бөхийн бүрэн өмсгөл гаргаж өгөөд:

-За хө. Сайн барилдана шүү. Тэнгэрийн тэвх шар бөх, газрын хавх хар гэж хоёр мундаг бөх ирсэн дээ. Би чиний засуул болно гэж хэлжээ.

Санамсаргүй энэ явдалд Хасар гайхаж баярлах зэрэгцэн,хэлэх үгээ олж чадсангүй бөхийн өмсгөлийг яаран өмсөж бүргэдийн дэрвэлтээр дэвэн гарч гэнэ. Наадмын бөхийн барилдаан гурван сар үргэлжилж шувтаргандаа ойртож гэнэ. Аргагүй л тэнгэрийн тэвх шар бөх, газрын хавх хар бөх, бас нэг бөх, Хасар хүү энэ дөрөв үлдэж гэнэ.

Тэнгэрийн тэвх шар бөх хоёр гартаа хорин засуулаа өргөөд л тэнгэрийн салхийг ч сөргүүлэн дэвж байна гэнэ. Газрын хавх хар бөх гучин засуулыг гартаа өргөөд л газрын хөрсийг хотолзтол дэвж байна гэнэ. Хасар нөгөө бөх хоёр жирийн л бөхийн ёсоор дэвж гэнэ.

-Наадамчин түмэн олны хараа дөрвөн бөх дээр тус гэнэ. Цас уулын Цагаан сахалт хаан ч Мөнгөнсаран охинтойгоо ирж сүүлчийн дөрвөн бөхийн барилдааныг үзэж гэнэ.

Хасар хүү эхлээд газрын хавх хар бөхтэй барилдахаар орж гэнэ. Газрын хавх хар бөх бол барьсан газраасаа бариулын чинээ, хүрсэн газраасаа хүрэн чинээ мах авч хаядаг хүч тэнхээ нэн ихтэй гэнэ. Хавх хар бөхийн засуул нь хар санаатай, хачин өөдгүй амьтан тул хавх хар бөхийгөө хальтарч унах вий гээд зөөлөн гурилыг хормой хормойгоор хөл дор нь асгаж, Хасарын дор тэмээний хатсан хоргол цацаж хальтруулж унагах гэж мэрийж байна гэнэ.

Хасар хүчтэй гэж хавх хараас ч айсангүй, хальтарна гэж хатсан хорголоос ч бэрхшээсэнгүй, өглөө мандах нарнаас оройн жаргах нарыгхүртэл барьцаа сайн хангаж хүчээ сайн хурааж гүйцээд гуян дээрээс нь авч гучин гурав эргүүлээд, далан дээрээс нь авч далан гурав эргүүлээд далан толгодын цаана далд ортол нь чулуудаж гэнэ. Наадамчин олон нэрхийтэл уухайлж Хасар хүүгийн хүчтэй чадалтайг хүн болгон бахдав гэнэ.

Хүчит бөхийн сүүлчийн даваа үзүүр, түрүүг булаацалдахаар Тэнгэрийн тэвх шар бөх, Хасар хоёр мянган засуул дагуулан гарч ирэв. Тэнгэр газраас ирсэн наадамчин олны хараа хоёр бөх дээр төвлөрөв. Тэнгэрийн тэвх шар бөх хоёр гартаа тавь тавин засуул тэврэн газрын хөрсийг хотолзуулан дэвж байна гэнэ. Хасар түүний тэнхээтэй хүчтэйгээс ч сүрдсэнгүй, гагцхүү Мөнгөнсаран бүсгүйн суугаа их асрын зүг байн байн харж, “Хэрэв би энэ бөхөд унавал тэр сайхан хүнээ үүрд алдах болно” гэж бодох аж.

Энэ үед их асарт Цаст уулын цагаан сахалт хаан Хасарыг ихэд сонирхож:

-Ийм сүрхий хүү гэнэт хаанаас гарч ирэв, хэмээн асуухад Хасарын хаанахын хэн болохыг хариулж чадах хүн хараахан тэнд байсангүй. Харин түүний өргөмөл охин Мөнгөнсаран л Хасар хэн болохыг бүгдээс илүү сайн мэдэж Хасарын төлөө хамаг сэтгэлээ зориулж байлаа.

Хоёр бөх барилдахаар өрөхөд засуул өвгөн Хасарын чихэд нь шивнэн: “Тэвх шар бөхтэй өрсөж барилдаад хэрэггүй. Хорьж барилдах хэрэгтэй. Хоёр өдөр хорьсны эцэст гуравдахь өдрийн үл дундын наран шарах үеэр тэр мш их хүч орж чамайг дайрна. Яг тэр агшинд их асраас сайхан хөгжим уянгална. Сонор дэлдэн сэтгэл алдруулсан тэр сайхан хөгжмийн аянд түүний хүч өөрийн эрхгүй сулрах буй заа. Харин чиний хань болох сайхан бүсгүйн хөгжмийн эгшиг чамд хүч нэмэх биз ээ. Тэр цагт чи санасан мэхээ зоригтой хийгээрэй” гэж хэлэв.

Хүчит хоёр бөх уулыг толгой, толгойг дов болтол хоёр бүтэн өдөр барилдаж эс

дийлэв. Гуравдахь өдрийн нар эгц дээрээс төөнөхөд тэнгэрийн тэвх шар бөхийн тэнхээ усны үер адил түрэн орж ирэх тэр л агшинд наадмын их асраас нартад ер сонсдоогүй сайхан хөгжим цууриатахад тэвх шар бөх тэр зүг рүү анхаарч оргилон орж ирсэн хүч тэнхээ нь огцом гэгч нь харьж, Хасарыг биенээс барьж байгаа эсэх нь бараг мэдэгдэхгүй болж гэнэ.

Харин Хасарт хайрт хүнийхээ хөгжмийн аяыг сонсоод судсаар нь аргих хүч тэнхээ түрж Тэнгэрийн тэвх шар бөхийг гуян дээрээс нь барин авч гучин гурав эргүүлэв. Далан дэрээс нь барин авч далан гурав эргүүлэн газар шидэв гэнэ. Ингээд Хасар дэвэн дэвсээр Цагаан сахалт хааны өмнө очин сөгдөж:

-Нэг найр минийх болов уу? гэсэнд хаан толгой дохин зөвшөөрөв гэнэ.

Эртэй чадалтай эрэмгий цогтой сайн эрчүүдийн дунд явуулах хоёрдахь тэмцээн буюу мэргэнхарваачдын тэмцээн эхэлж гэнэ. Өглөө тавьсан сум орой хүрэхээр хол гэнэ. Тэгэхдээ тавьсан сум нь бага үдэд мөнгөн тэвнийн нүхийг сэтлэлгүй гарч, их үдэд алтан тэвнийн нүхийг мөн сэтлэлгүй гарч, орой нар шингэх үед тавин тэрэг түлээг шүд чиглэх юмгүй болтол бут харвах ёстой. гэнэ.

“Нэг наадмаа алдсан хоёр наадмаа алдахгүй дээ” гэсэн Газрын хавх хар, Тэнгэрийн тэвх шар, Хасар гурав шалгаран үлдэж гэнэ. Наадамчин олон тэр гурвын харвааг сонирхон талаас уулын орой хүртэл тухлан хүрээлэн сууцгааж гэнэ.

Тэр өглөө туслагч өвгөн Хасарт булцуу нь алт, өд нь зэс гол нь мөнгөн нэгэн сум авчирч өгөөд:

-За чи энэ сумыг ургахын улаан нарнаар татаж өнжин өнжин татаж, хонон хонон татаж, маргааш өглөө ургахын улаан нараар эрхийн хуруунаас чинь төлгөн чинээ цус дусах үед тавиарай гэж захив.

Ингээд эхний өдөр Газрынхавх хар бөх сумаа тавьсанд түүний сум мөнгөн тэвнийн хүхийг сэтлэлгүй гарч алтан тэвнийн нүхээр арай оролгүй унаж гэнэ. Дараа өдөр нь Тэнгэрийн тэвх шар бөх сумаа тавьсанд мөнгөн тэвнийн нүхийг сэтлэлгүй гарч, алтан тэвнийн нүхийг сэтлэлгүй гарч, тавин тэрэг модны талыг нь бут харважээ. Гуравдахь өдөр нь Хасар сумаа тавьсанд мөнгөн тэвнийн нүхийг сэтлэлгүй гарч, алтан тэвнийн нүхийг сэтлэлгүй гарч, тавин тэрэг модыг бут харваад зогссонгүй, түүний цаана байсан үхрийн чинээ цагаан чулууг хэтэнд хийх юмгүй болтол харваж, бутарсан очноос нь бадарсан түймэр гарч бөөх хөл болж байна.

Ингээд Хасар хүү хаанд бараалхаж:

-Хоёр наадам минийх болов уу? гэж асуухад хаан зөвшөөрч гэнэ.

Ингээд Цас уулын Цагаан сахалт хааны их наадмын сүүлч болох хурдан морьдын уралдаан эхлэх болж гэнэ.

Хоёр найр Хасарынх болсон ч морьдын уралдаан түүний сэтгэлийг шаналгаж байлаа.

Анх морьд гараа руугаа явахад хааны тогтоосон гурав үдлэх газраас уралдах байсанд Газрын хавх хар, Тэнгэрийн тэвх шар тэргүүлэн “Хонины хүүхдүүдийн тоглоомын газраас морио уралдуулахгүй” гэгцгээж “Газрын хавх хар нь Гурван сарын газраас уралдуулна” гэхэд Тэнгэрийнтэвх шар нь гурван жилийн газраас уралдуулна гэжээ. Ингээд хаан эзэн тэргүүлэн хамаг бүгдээрээ хэлэлцэж байж, гурван сарын газраас хурдан морьдыг уралдуулахаар тогтсон юм байжээ.

Хасар хүүгийн өчүүхэн муу бор даагыг унаж өгөх хүн олдсонгүй гэнэ. Аргаа барж явсаар байтал идэхээрээ цаддаггүй, цадахаараа унтдаг, унтахаараа сэрдэггүй нусгай муу хүү дайралдаж гэнэ. Хасар нөгөө хүүд ингэж захиж гэнэ:

-За миний дүү гарааны газар очтолоо морин дээрээ унтаж хүрээрэй. Гараанаас гарахдаа хоёр шуудай элс авч гараарай. Нэг шуудайг нь морьдын цээжинд гарч ирээд хагалаарай. Нөгөө шуудайг нь морьдын түрүүнд гарч ирээд хагалаарай! гээд хоол хүнсийг нь базааж өгөөд явуулж гэнэ.

Уралдааны морьд явсаар хүрэх газраа хүрч эргэх үедээ идэхээрээ цаддаггүй, цадахаараа унтдаг, унтахаараа сэрдэггүй хүү хамагхоол хүнсээ цадталаа идээд, унтаад өгчээ. Морьд гараанаас гараад уджээ. Хасарын бор даага идэмхий, нойртой нөгөө хүүг сэрээж цөхөөд унгалдан янцгааж, цомбон дөрвөн туурайгаараа тэгш газрыг нүх болтол цвчлан байж цөхөж байсан ашгүй аргал түүсэн нэгэн эмгэн ирж унтсан хүүгийн хамар руу ус цутгаж байж сэрээж гэнэ. Тэгээд:

-Хүний итгэл хүлээж хэрэг албанд нь авчихаад эзэнгүй хээр ирээд унтчихдаг ямар ёс вэ? хэмээн загнаж гэнэ.

Хүү нойрмог нүдээ нухлан

-Уралдааны морьд гараанаас гараад удаж байна уу? гэж асуув. Эмгэн уулга алдаж:

-Чи чинь уралдаж яваа хү үү? Эй халаг гэж, морь эргээд сар болж байна гэхэд хүү сандран эмгэнтэй хамжиж хоёр шуудай элс ганзаглаад бор даагандаа мордов.

Бор даага шашир дэлээ намируулан үүлэнд умбан, агаарт цойлон давхив. Хүү чухам л дэлнээс нь бат атгаж, нүдээ тас аньж мориныхоо нуруунаас салахгүйг л хичээв. Нэлээд яваад нүдээ нээгэл үүл үү? уул уу? гэмээр улаан тоос тэнгэрт босч байгаа нь уралдааны морьдын тоос ажээ.

Хамгийн сүүлд явсан нэг хүүхэдтэй зэрэгцэж очоод:

-Бид нар одоо газрын тал дунд орсон болов уу? гэж асуухад:

-Газрын тал дундаас өнгөрөөд долоо хоног давхиж байна гэж хариулав.

Цааш явах тутам морьд улам ихдэж агтын хөлөөр шидэгдсэн чулуу шороо амьсгал авхуулахгүй хоёр гурав хонов. Дахиад нэг нүдээ нээсэн чинь ихэнх морьд аль хэдийнээ ард үлдэж,хэдэн хурдан морьд зуузай холбон хурдалж байна гэнэ.

Хүү ганзаглаж явсан нэг уудай элсээ хага татсанд асар их элсэн шуурга болон дэгдэж гэнэ. Унтаж хоцорсон хүүгийн сэтгэл жаахан уучирж, нэлээд явтал өмнө нь бас л хуйларсан их тоос босч байгааг олж харав. Энэ чинь юу их тоос байдаг билээ? гэж өөрөөсөө асууж унасан хүлгийнхээ жолоог султган хурдлав.

Тэр их тоосыг гүйцэн очвол Тэнгэрийн тэвх шар, Газрын хавх харын хурдан морьд хуй салхи мэт хурдалж байна гэнэ.Хүү тэднийг хоромхон гүйцэж өнгөрөхдөө нэг шуудай элсээ ханзалтал элсэн уул болж хойно нь дүнхийж гэнэ.

Ингээд цааш долоо хоног давхитал барианы газар ойртож наадамчин олон багширч ёстой л хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөнө гэгч болж байна гэнэ.

Газрын хавх хар, Тэнгэрийн тэвх шар хоёр бүхнээс давамгайлан “Миний хар морь байна, миний шарга морь байна” гэж ам булаацалдан бардамнаж алд алдын дурангаар харж байна гэнэ.

Хасар дурандах дуран ч байсангүй. Хоньчинхүүгийн өгсөнбор даагыг түрүүлж ирэх нь бүү хэл, гарааны газар очоогүй ч байж магадгүй гэж бодон амьтан хүний ар өврөөр холхиж ядан байв.

Гэтэл хүмүүс дуу алдан үүлэн бор морь байна. Хэний морь вэ? Ёстой л хурдан хүлэг юм даа. Гурван сарын газрыг хоёрхон сар явдаг, жигүүрт хурдан морь байна ! гэж шуугилдахад Тэвх шар, Хавх хар хоёр:

-Хэ цэс! Энэ лав газар дундаас гарсан морь байж таарна. Түүнээс биш ингэж яаж ирж чаддаг юм гэхэд нэгэн хүн:

-Сайн хараарай. Араас нь морьд айсуу байна. Их тоос гарч байна. Энэ лав цойлж түрүүлсэн морь байна.

Тэвх шар, Хавх хар хоёр дурангаа арчин арчин дурандав. Ингээд л хэн ч зүсэлж тогтоогоогүй, үүлэн цэн хэр морь үүлтэй тэнгэрийн доогуур ган дөрвөн туурайнаасаа оч бутарган, шашир сайхан дэл сүүлээ намирууланхан барианд орж ирэв.

Хасар морио эхлээд таньсангүй. Даахьтай бор даага л ирвэл ирнэ гэж харж байсан аж. Гэтэл дээр нь суусан хүүг харвал мөн байна гэнэ. Хасар уулга алдан баярлаж морио барьж авлаа. Ингээд Хасар Цас уулын Цагаан сахалт хаанд бараалха:

-Гурван наадам минийх болов уу? гэж асуухад хаан зөвшөөрөв гэнэ.

Ингээд Цаст Уулын Цагаан сахалт хаан Мөнгөнсаран охиныхоо хуримыг хийж амласан ёсоор Хасарт охиноо өгч гэнэ. Харин хаан ширээгээ залгуулахаар Хасарын хүү Энхмөнхийг авч үлджээ.

Цагаан сахалт хаан охиноо явуулахдаа Мөнгөнсарангаас

-Хаан аавд чинь бүх зүйл бий. Чи юу дуртайгаа ав гэж гэнэ. Мөнгөнсаран түр зуур бодолхийлж байснаа:

-За ааваа надад нэг их юм хэрэггүй. Та намайг ачлал хайраараа ивээж өдий зэрэгт хүргэлээ. Би таны тусыг хэзээ ч мартаггүй, хаана ч байлаа гэсэнтаны охин хэвээр байх болно. Та надад үнэхээр хайртай бол таны өргөөнд байгаа алт, мөнгө, хүрэл гурван хайрцгийг чинь л авъя гэж хэлэв.

Цагаан сахалт хаан охины цэцэн цэлмэг ухаантайг магтаж буруу харж уйлан, зөв харж инээн байж гурван хайрцгийг өгч гэнэ.

Охих, хүргэнийг бараа болж явах хүмүүс гайхацгааж “Энэ их хөрөнгөнөөс тэр муу гуравхан хайрцгийг авдаг ямар гэгч хүн байдаг билээ” гэж дуу алдаж гэнэ. Ингээд Мөнгөнсаран, Хасар хоёрын хуримын цуваа нутгийн зүг сүр бараатай хөдөлж гэнэ.

Тэд явсаар эхлээд үүлэн бор морийг өгсөн малчныд саатаж гэнэ. Тус сайхан сэтгэлд өгөөмөр тэр өвгөнд сүрэл хайрцагтай зүйлийг Хасар, Мөнгөнсаран хоёр бэлэглэж гэнэ. Тэр хайрцаг дотор дүүрэн цэцэн ухаан байж гэнэ. Тэр цагаас эхлэн хүмүүс цэцэн ухааныг авч гэнэ. Тэгэхдээ тэр цэцэн ухаан хэзээ ч дуусдаггүй гэнэ.

Хасар Мөнгөнсаран хоёр цааш явж байгаад нум сум өгсөн өвгөн, эмгэн хоёрынд очиж гэнэ. Тэднийг авьяас чадвар, ач тусыг бахдахынихээр бахдаж, мөнгөн хайрцагтай зүйлээ бэлэглэж гэнэ. Мөнгөн хайрцаг дотор нь үсэг бичгийн цагаан толгой байж гэнэ. Тэр цагаас эхлэн хүмүүс бичиг үсэгт суралцаж Хасарт нум сум бэлэглэсэн мөнөөх өвгөн бүх улсын номын багш болж гэнэ.

Хасар, Мөнгөнсаран хоёр цааш явсаар анх уснаас татаж гаргаад, алтан амийг нь аварсан ачтай өвгөн, эмгэн хоёр дээрээ очиж гэнэ. Эмгэн өвгөн хоёр хөл алдан баяр хөөр болж гэнэ. Хасар, Мөнгөнсаран хоёр эмгэн өвгөн хоёрын цаглашгүй ачийг юугаар ч эс хариулж чадахаа илэрхийлж алтан хайрцагтай зүйлээ бэлэглэж гэнэ. Тэр алтан хайрцаг дотор үхэлгүй мөнхийн амьдрал, үгүйрэшгүй аз жаргал хоёр байж гэнэ. Үхэлгүй мөнхийн рашаан нь үрээс үр залгаж, үүлт тэнгэрийн дор хүний ертөнц мөнхөд дэлгэрсэн нь тэр болой.

Хасар Мөнгөнсаран хоёр цааш одож ноён эцгийн дээ очиж гэнэ. Ноён эцэг, хатан ээж хоёр нь үзэсгэлэн гоо охин Мөнгөнсаран, үнэнч сэтгэлт хөвгүүн Хасар хоёрыг үзээд ухаан алдан уймарч хорвоогийн нар дахин мандах шиг аз жаргалд умбаж гэнэ.

Ачлал хайраараа ивгээн ариун цагаан сүүгээрээ амилуулан тэжээсэн аав ээж хоёрыгоо хайрлахын ихээр хайрласан охин хүргэн хоёр нь эцэг эх хоёртоо бүхнийг уяруулан татах увьдас хүчин төгөлдөр сайхан дуугаа бэлэглэж гэнэ. Тэр сайхан дуу эдүгээг хүртэл хүн ардтай хамт явж хөдөлмөр амьдралд нь жигүүр болж иржээ.

Мөнгөнсаран, Хасар хоёр явсаар адуучин өвгөн Асралт аавындаа ирж гэнэ. Х айрт хүү нь эсэн мэнд явж хамгаас үзэсгэлэнтэй Мөнгөнсарангаа олж ирсэнд эх эцэг хоёр магнай хагартлаа баярлаж гэнэ. Мөнгөнсаран, Хасар хоёр ээж аав хоёртоо юу ч авчирсангүй. Гагцхүү хоёр сайхан биеэ л авч иржээ.

Тэр хоёр сайхан хүн ёстой л юунаас ч үнэтэй эрдэнэ ажээ. Эцэг эхэд үр шиг нь үнтэй юм үгүй билээ. Эцэг эх шиг ачтай юм үр хүүхдэд нь үгүй билээ.

Эцэг, эх үрийн ариун жаргал тийнхүү дэлгэрч энэ орчлонд тэр сайхан нандин холбоо хэлхээ хэзээ ч тасаршгүй болсон нь тэр гэнэ. Ингэж хүний ариун ургийн холбоо алтаннарны дор үүрд мөнх оршсон үлгэр ингэж дуусав. Эрт дээр цагт нэгэн айл “Үгүй”, “За” гэдэг хоёр хэдтэй байж гэнэ. Үгүй бол юм хий гэхэд дандаа “үгүй” гэж хариулдаг. Харин “за” бол юм хий гэхэд үргэлж “за” гэж хариулдаг, тэгээд хийдэг ч байж гэнэ.

Эцэг эх хоёр нь энэ “үгүй”-г явал “за” гэдэг болгох вэ? гэж бодож цөхөөд эцэст хоёулаа Үгүйг алс газар явуулбал За-г сурч магадгүй. Тийм учраас ахтай нь хамт явуулья гэж шийджээ. Тэгээд эх эцэг хоёр, хоёр хүүгээ алс газар үдэж гэнэ.

За, Үгүй хоёр явсаар байтал өмнө нь нэг их том уул тааралдаж гэнэ. Хоёулаа авч явсан сүүлчийнхээ хүнсийг идэж дуусаад унтаж амарчээ. Ингээд өглөө босч цааш явах гэсэнд Үгүй нь:

-Би чамтай хамт явахгүй ээ. Энэ уулын хоёр талаар яваад уулзъя гэж гэнэ.

За нь ямагт үгүй гэж хариулдаг, юу ч сураагүй дүүгээ өрөвдсөн боловч, түүнтэй зөрж маргахыг бодсонгүй, саналыг нь зөвшөөрч:

-Миний дүү чи бол алив зүйлийг үгүй гэсээр байгаад юу ч хийж сураагүй хүн. Чамд бэрхшээл саад тохиолдож болно. Түүнийг зоригтой авхаалжтай даван туулах хэрэгтэй гэж захиж гэнэ. Ингээд тэр хоёр салж хоёр замаар явжээ.

За хүүгийн хувьд зовлон бэрхшээл төдийлөн тааралдсангүй. Яагаад гэвэл За бол хүний хэлсэн үгэнд дуулгавартай хийс, сур гэсэн зүйлийг ямагт за гэж хүлээн авч түүнийг заавал биелүүлдэг учраас ямар ч ажлыг сайн хийж сурчээ. Ийм болохоор түүнд идэх хоол, өмсөх хувцас хүссэний хирээр олдож явжээ. Харин ч За хүү нэгэн эрдэмт хүнд шавь орж хэдэн жил суугаад аз жаргалтай сайн явж гэнэ.

Үгүй хүү үнэхээр бэрхшээлтэй замыг туулж гэнэ. Ажил хөдөлмөрөөс ямагт зайлсхийж, биеийн амрыг хардаг түүнд идэх хоол, өмсөх хувцас олдсонгүй. Гэдэс нь өлсөж, гэрээс өмсөж гарсан хувцас нь ч урагдаж ноорчээ. Үгүй хүү өлсөж цангахын туйл болж явсаар нэгэн айлд орж ирвэл нас сүүдэр дээр гарсан эмгэн:

-Ус аваад ирвэл цай хийж өгье. Аргал түүгээд ирвэл хоол хийж өгье. Хонь хариулж өгвөл хувцас хийж өгье гэж гэнэ. Үгүй хүү төрөлхөөс залхуу учраас За гэж хэлж чадсангүй. Нөгөөх л хэлж сурсан Үгүй гэдгээ хэлж гэнэ. Эмгэн ихэд уурсаж:

-Өдий багаасаа үгүй гэхээс өөр үг сураагүй яачихсан амьтан гэгч вэ? Зайл гэж хөөж гэнэ.

-Үгүй хүү эмгэний харамч хатуу сэтгэлтэйд гоморхон цаашаа явжээ. Ингээд цааш гэлдэрч явтал адуучин эр урт уургаа суналзуулан давхиж явна гэнэ. Хүү адуучинд хандаж:

-Надад идэх юм өгөөч, би маш их өлсөж явна гэж гуйжээ. Адуучин:

-Би чиний өлсөж, цангаж явааг мэдэж байна. Тэгэхлээр чи надад унага татаж өгвөл нь би чамд айраг өгнө. Адуу хурааж өгвөл нь хоол өгнө гэжээ. Үгүй хүү уруул чимчигнэсэн сайхан айргийг залгимаар санагдаж гэнэ. Амттай сайхан хоолыг цадталаа идмээр бодогдож гэнэ. Гэвч унага татах, адуу хураах гэдэг айхтар сүрхий ажил санагдаж:

-Үгүй дээ ах минь гэжээ. Адуучин эр бухимдаж:

-Өдий багаасаа үгүй гэхээс өөр үг мэддэггүй өөдгүй залхуу амьтан байна чи. Хүний хөлс хүчээ шавхаж байж бүтээсэн юмыг чи зүгээр л хэрэглэх үү? Өлсөж цангаад л дуртай замаараа явж байвал таарна гэж хэлээд давхиад явчихжээ.

Үгүй хүү цааш явж байтал аадар бороо орж модны дор хоргодон сууж гэнэ. Бороо намдмагц улаан шоргоолжнууд, үүрнээсээ гарч зарим нь өт хорхой цуглуулан, үүр рүүгээ арай чамай чирч, зарим нь үүрэн дотроосоо хог хаягдлаа зайлуулж огт завгүй байв. Үгүй хүү “энэ муусайн шоргоолжнууд яахлаараа ингэж завгүй байдаг байна вэ? Эд юуны төлөө ингэж чадал тэнхээгээ барна вэ? Энэ их ойд бэлэн хоол зөндөө байхад олж идчихээд л хаа тааралдсан газраа унтаж амраад л явж байвал жаргалтай баймаар юм. Тэгээд ийм олуулаа. Бас ийм том үүртэй. Ийм жижигхэн амьтад байж яаж энэ том үүрийг барьж чадна вэ?” гэж бодож гэнэ.

Ой дундуур явтал модонд шувууны үүр байх бөгөөд түүнд олон ангаахай шуугьж биендээ томдсон улаан амаа ангалзуулан байна гэнэ. Энэ үед амандаа идэх юм зуусан эх шувуухай нь нисэн ирж тэдний ховдог ам руу идэх юм хийж аж. Үгүй хүү, “Айдаа, гэдэс минь тун ч их өлсөж байна. Ээж аав хоёр минь ойрхон байсан бол миний аманд ингээд л идэх юм хийнэ дээ” гэж бодож гэнэ.

Тэгээд Үгүй хүү цааш явтал бутанд жимс, модонд самар байгааг олж харжээ. Тэр жимснээс авч идэх гэсэн боловч залхуу нь хүрээд авч чадсангүй. Модонд болсон сайхан самар байвч мөн л авч идэж чадсангүй.

Үгүй хүүгийн гэдэс нь тасрах шахам өлсөж байна гэнэ. Ингээд арга, учраа олж ядан зогсож байтал сүх, хөрөө үүрсэн урт цагаан сахалтай өвгөн хүрч ирж гэнэ. Өвгөн хүүтэй уулзаж хэрэг зориг нь юу болох, хэт нутаг нь хаана болохыг асуун сонирхож гэнэ. Үгүй хүү:

-Би ахтайгаа хамт гэрээс гарч нэг уулын хоёр талаар явж, дараа нь хоёулаа уулзахаар тохиролцсон юм. Ингээд би замдаа өлсөж цангаж явна. Нэгэн эмгэнийд очлоо, бас нэг адуучин хүнтэй уулзлаа. Тэр хоёрын хэн нь ч надад тус болж идэх юм өгсөнгүй. Одоо би үхэх нь ! гэж хамаг учраа ярьж уйлж гэнэ. Цагаан сахалт өвгөн:

-За яахав, би чамд тус больё гээд янз бүрийн жимс, самрыг бөөн бөөнөөр нь түүж хүүд өгөөд модондоо яваад өгчээ.

Үгүй хүү баярлахын ихээр баярлаж өвгөний авч өгсөн сайхан жимс самрыг амтархан идэж, амарч суутал өвгөн модоо түгээд ирж гэнэ. Өвгөний амьсгаа нь давхцан, хөлс нь цутгаж, түүсэн модоо арай ядан чирсээр иржээ. Үгүй хүү өвгөнийг ихэд өрөвджээ. Өвгөн түүнд жимс түүн өгч, бүр тэгэхдээ амны нь цангаа гаргах хамгийн сайхан исгэлүүн жимсийголож өгсөн билээ. Үгүй хүү:

-Би танд тусалъя. Модноос чинь чирэлцье гэжээ.

Өвгөний сэтгэл ихэд сэргэж хүүгийн хүсэлтийг дуртайяа зөвшөөрч хоёулаа явжээ. Үгүй хүү тэднийг ирж цадталаа хооллож, бас шинэ сайхан хувцастай болж гэнэ. Хүү тэднийхээс явах гэсэн боловч цагаан сахалт өвгөнорой бүр ямар нэгэн эрээн цоохор юм харж урьд өмнө огт сонсож байгаагүй үлгэр түүхийг уншиж өгөх нь нэн их сонирхолтой байжээ. Тэгээд Үгүй хүү нэгэн өдөр өвгөнөөс:

-Таны энэ эрээн цоохор юм чинь ямар ид шидтэй юм бэ? Та үүнийгээ хараад ертөнцийн алив зүйлийг тайлан унших юм гэхэд:

-Энэ бол “Мэддэгт мэргэн цоохор, мэддэггүйд эрээн цоохор” гэгч бичиг ном юм. Үүнийг сурсан хүн үгүйршгүй баян, хэмжээлшгүй оюун ухаантай болдог юм. Хэрэв чи үүнийг сурья гэж байгаа бол би чамд зааж өгч болно гэжээ.

Би чухам үүнийг чинь л сурья. Надад өөр юу ч хэрэггүй. Би таны хий гэсэн болгоныг хийж чадна гэж хүү амлажээ. Энэ үгийг сонсоод өвгөн ихэд баясаж:

-Хэрэв чи үнэн сэтгэлээсээ ингэж шийдсэн бол би юунд дургүйцэх билээ. Гагцхүү залхуурч үгүй, чадахгүй, мэдэхгүй гэдэг үгийг л нэг ч удаа хэлж болохгүй. Тэгвэл бичиг, ном чиний оюун ухаанд огт тогтохгүй. Чи бүх насаараа тогтоох гээд ч нэмэргүй. Чи тэгж чадах уу? гэж асуув. Хүүгийн сэтгэл ихэд хөдөлж:

-Би чадна. Бүр андгай тангаргаа тэнд өгье гэж зоригтой хариулжээ.

Ингээд Үгүй хүү нөгөөх өвгөнд шавь орж бичиг ном заалгаж гурван жил болжээ. Алив зүйлээс бэрхшээж, залхуурахаас биш оюун ухаан сэргэлэн тэр хүү бичиг номд шамдан сайн сурчээ. Ингээд нэгэн өдөр өвгөн, хүүг дуудаж ирүүлээд:

-За чи сайн хүү байна. Надад амласан зүйлээ биелүүллээ. Үг бол үнэтэй зүйл юм. Амнаас гарсан цаг эргүүлж авч бодоггүйгээрээ үгийн үнэ цэн нь түүндээ байдаг. Тэгвэл чи надад хэлсэн үгээ биелүүлж Үгүй, чадахгүй, мэдэхгүй гэдэг үгийг нэг ч удаа хэлэлгүй байсны ачаар чи эрдэм номд сайн суралцлаа. Одоо чи явах хэрэгтэй. Ахыгаа олж уулза. Энд нэлээд удчихлаа гэжээ.

-Би танд их баярлалаа. Таны ачаар би ямагт хэлдэг Үгүй гэдэг үгийг хэлэхээ байлаа. тэр үгийг хаяснаар би эрдэм ном сурлаа. Ажил хийж сурлаа. Таны энэ их ачийг би хэзээ ч мартахгүй. Би эцэг эхийн хайрыг хэтрүүлж “За” гэхийн оронд дандаа Үгүй гэдэг учраас намайг хүн богон Үгүй хүү гэж нэрлэдэг болсон юм. Тэр муу нэрээ би ээж аавдаа эргэж очоод үүрд солих болно гэж хэлээд явжээ.

Тэгж явсаар нэгхот газар ирж гэнэ. Тэр хотын нэг онцлог нь түүнд бичиг үсэг мэдэх хүн огт байхгүй ажээ. Тэр хотын захирагч сэргэлэн ухаант нэг хүүтэй гэнэ. Тэр хүү нь нэгэн тоглоомоор гурван настайгаасаа эхлээд арван найман насыг хүртэл тоглосон аж. Тэгээд хотын захирагч нас дээр гарч хүүгээ эрдэм номтой болгохсон гэж туйлаас хүсэж хүүдээ эрдэм ном заасан хүнд юугаа ч хайрлахгүй хэмээн нийтэд зар тараажээ.

Үгүй хүү хотын захирагчийнхыг заалган тэднийд хүрч очжээ. Бичиг үсэг сайн мэддэг мэргэн ухаант хүн гэнэт хүрч ирсэнд хотын захирагч машид баярлан угтжээ.

Үгүй хүү тэднийд байж өөртөө тохилог сайн орон байртай, идэх хоол, өмсөх хувцас, чухам л юу дуртай бүхэн өрөөстэй, сайхан амьдарч хүүд нь бичиг ном зааж эхэлжээ. Тэгээд хүү нэг өдөр гурван настайгаасаа эхлэн, арван найман насыг хүртэл тоглосон тэр тоглоомыг нь сонирхох хүсэлд автаж, түүнийг нь анхаарчээ.

Жижигхэн дөрвөлжин хөлөг дээр, хоёр хүн тоглох тэр тоглоомыг шатар гэдэг аж. Хотын захирагчийнх үүг хожиж наадах хүн тэр орчинд байсангүй тул тэр тоглоомоороо тоглохоо бүр байжээ. Ингээд Үгүй хүү:

-Би танд бичиг ном зааж сургая. Харин та надад энэ тоглоомоо зааж өгөхсөн болов уу? гэж гуйжээ.

Захирагчийн хүү дуртайяа зөвшөөрч:

-Энэ тоглоомыг их л удаан сурдаг тоглоом. Сураад байх тусам улам мэдэхгүй болж

шинэ шинэ арга ухаан ар араасаа ундрэн гарч ирдэг юм гэжээ.

-За яахав, би таныг бичиг үсэг сурч гүйцтэл л заалгая. Сурч чадвал миний зол, сурч чадахгүй бол миний хохь биз гэжээ.

Ингээд Үгүй хүү захирагчийн хүүд бичиг зааж, захирагчийн хүү Үгүйд шатар заажээ. Тэр хоёр гурван жил болоход хэн хэн нь зааснаасаа заалгасан нь илүү сайн сурчээ. Хотын захирагч алба үйлсээ залгуулах хүүд нь бичиг ном зааж өгсөн тэр ачтай хүүд баярлахын дээдээр баярлаж:

-Хэрэгцээтэй, юу дуртайгаа ав! гэжээ

-Би ч танд их баярлалаа. Танай хүү надад шатар зааж, би таны хүүд бичиг ном зааж хоёулаа аль алиныг нь сайн сурцгаалаа. Ингэхлээр би та нараас ямар ч шан харамж авахгүй гэж Үгүй хүү хэлээд цааш аян замдаа оржээ. Ингэж явсаар уулын зам дуусч өмнө нь их хот харагдав гэнэ. За энэ хотод л миний ах ирсэн байх даа. Ахыгаа хаанаас яаж олдог билээ?" гэж бодсоор хотын зах руу орж ирж гэнэ.

Үгүй хүү хотод ирж ахыгаа сурагласанд ах нь тэр хотод дээгүүр тушаалын нэгэнтүшмэд болсон тул амархан олж очжээ. Олон жил уулзаагүй ахыгаа олж очсон боловч ах нь их л уруу царайтай үг дуу цөөнтэй байж байна гэнэ. Үгүй хүү:

-Ах минь та яагаа вэ? Бие чинь зүгээр үү? гэж асуухад:

-Миний бие зүгээр ээ. Эдэлж хэрэглэх элдэв зүйл цөм бүрэн байна. Гэвч ахад чинь золгүй явдал тохиолдоод байна. Энэ зовлонгоос гэтэлж хайрт аав ээжтэйгээ амар мэнд уулзах хувьгүй болоод байна гэжээ.

-Яагаад тэр билээ? Би танд тус болж чадахгүй юм гэж үү? Та надад учир явдлыг тодорхой ярьж өгөөч ! гэж гэнэ.

-Ай, миний дүү хол газар их зүйл туулж олон зүйл сурч мэдсэн байлгүй. Тэгэхдээ надад тус болох тэр зүйлийг сурч ирээгүй биз дээ хэмээн сэтгэл дундуур байна гэнэ.

-Ах минь та надад итгэж тэр аюул зовлонгоо хэлж өгөөч дээ. "Амьд хүн аргатай" гэдэг үгийн учрыг би биеэр үзэж ирлээ шүү дээ гэж дахин дахин гуйжээ. Ингээд Үгүй хүүгийн ах За учир явдлыг ийнхүү хэлж гэнэ.

-Манай хаан шатарт туйлын дуртай хүн. Тэр хааныг хожих хүн ер үгүй гэнээ. Хаан эзэн сүүлдээ харгис хууль гаргаж өөртөө хожигдсон хүний толгойг авдаг хатуу зарлиг буулгасан юм. Иймд түүнтэй тоглох хүн огт олдохгүй болж, хаан хавьтсан ойртсоноос нь эхэлж эцэс сүүлдээ шадар сайн түшмэлүүдээ хүртэл халз тоглолтод дуудаж тоглодог боллоо. Нэг ч хүн амьд эргэж ирсэнгүй. Ингээд маргааш миний ээлж болсон. Хаан намайг дуудсан. Чи намайг мэдэж байгаа. Ах чинь залхуурах бэрхшээх, алив зүйлийг мэддэггүй хүн болохоор хүнд хэрэгтэй, тустай болгоныг сурсан билээ. Гэвч энэ шатар гэдэг тоглоомыг сураагүй юм. Гэтэл хааны зарлиг

хатуу тул давж гарах арга хүчин нэгэнт мөхөсдөөд сууж байна. Харин хайрт дүү чи бид хоёр ерөөлтэй төрсөн учраас амжиж чи минь хүрч ирлээ гэж ярив. Үгүй хүүгийн сэтгэл сая л нэг уужирч

-Ах минь таны айх аюул зайлах шиг боллоо. Дүү чинь ээж, аавдаа эрх танхи өсөж, ажил хөдөлмөрийн ач тусыг ойлгохгүй явжээ. Тэгээд л За гахын оронд Үгүй гэж сурчихсан гэмээ би ганцаар өнгөрүүлсэн энэ хэдэн жил ойлгож мэдлээ. Үгүй, чадахгүй, мэдэхгүй гэдэг чинь үнэхээр хүнд хамгийнхэрэггүй зүйл юм байна. Бас ямар асуултад Үгүй, чадахгүй, мэдэхгүй гэвэл зохихыг бас ойлгож авлаа. За-д бас учир бий юм билээ, ах минь. Хүн хичээвэл юуг ч хийж, юуг ч сурч мэддэг болохыг өөрийн биеэр үзлээ. Би эрдэмт хүнээр бичиг заалгаж гурван жилийг өнгөрүүллээ. Дараа нь сурсан эрдмээ хүнд зааж, оронд нь шатар заалгаж, гурван жилийг дуусгалаа. Ингэж явсаар хайрт ах таныгаа хүлээлгэж, эцст ийм хэрэгт унагасан байна. Тэгэхлээр би одоо таны ачийг хариулж тэр хаантай чинь халз тоглох ёстой. Би шатар сурсан шүү гэж хэлэв. За ахынх нь царайд баяр, гуниг ээлжлэн байж:

-Ээ дээ миний дүү тэр хааныг дийлэхгүй бол яана. Өөрийнхөө ороос дүүгийнхээ толгойг авахуулснаас өөрөө очиж дууссан нь дээр биз ээ. Ер нь тэгээд би зарим асуултад За гэж хариулж болдоггүйг ойлгоогүйгээс болж, ийм аюулд нүүрлэв үү дээ, дүү минь! За гэж байгаад шатар сурсан ч болоосой билээ гэхэд:

-Та надад найдаж болно. Бүү зов. Бид хоёр насаар ойрхон, зүс царайны хувьд усны хоёр дусал шиг адилхан болохоор таны хувцсыг би өмсөөд л очиж тоглоё гэлээ.

Ингээд ах дүү хоёр тохиролцож маргааш өглөө нь Үгүй дүү нь За ахынхаа хувцсыг өмсөж хааныд очиж гэнэ. Хаан хэн болхыг ч ер анзаарсангүй, тоглох шатраа аль хэдийнээ өрчихсөн, том сэлэм дэргэд нь тавьчихсан хүлээж байв гэнэ. Үгүй хүү хаантай мэндлээд тоглохын өмнө ингэж асуужээ.

-За хаан эзэнтэн минь шатрыг хэдэн удаа тоглох вэ? гэж асуухад:

-Нэг л тоглохгүй юу? гэжээ.

-За тийм байж. Тоглоод би хожигдвол та миний толгойг авах нь гарцаагүй. Харин та хожигдвол яах вэ? гэж их л зоригтой асууж гэнэ. Хааны царайд басамжлах байдал илт тодорч:

-За за! Намайг хожиж чаддаг хүн хаана ч байхгүй. Хэрэв чи намайг хожвол миний толгойг л авахгүй юу гэв.

-Үгүй дээ, эзэнтэн минь. Таны толгойг авна гэдэг харц надад алдас болно. Хаан та ч гэсэн амиа хэлтрүүлэх арга сүвэгчлэх болно. Ийм учраас яг л болох юмыг амлаж хайрлаач дээ ! гэж хүсч гэнэ. Хаанихэд хилэгнэн:

-За үхэхийнхээ өмнө юун ч олон үгтэй юм бэ? Би чам шиг хүүд хожигддог юм гэхэд толгойгоо өгөхөд айх юмгүй. Алив тоглоё гэж шаардаж гэнэ.

Ингээд харгалзагч, шүүгч олон хүн сууцгааж, тэр хоёрын тоглохыг харж гэнэ. Бага үд болоогүй байхад хаан хожигдох байдалтай болов. Хаан хамаг ухаанаа шавхан хар хөлс нь цувж эхлэхэд Үгүй хүү том сэлмийг өөртөө ойртуулж гэнэ. Их үдийн алдад хаан хожигдох нь гарцаагүй болжээ.

Хааны бардам зан, сүр сүлд нь балран унаж, хүүгийн өмнө ёстой өчүүхэн муу амьтан болж:

-Хамжлага ард, хамаг эд хөрөнгө чинийх болог ! Хаан төр минь чинийх болог, хар толгойг минь л өршөөж хайрла гэж бөхөлзөн гуйж өлмийд нь сөгдөн, өөд уруугүй дагаж гэнэ.

Ордны хиа, түшмэлүүдээс эхлээд орон даяарт мэдээ тарж

Хаан эзэн х ожигдож гэнэ. Хар толгойгоо л гуйж байна гэнэ. Айх аюул зайлсан нь яамай. Аюулт зарлиг нурах болтугай ! гэж олон ардууд шуугьж гэнэ. Үгүй хүү хааныг сүрдүүлж толгой дээгүүр нь том сэлмийг нэг эргүүлж:

-Хожигдсоныг алдаг зарлигаа урж хаясугай ! гэж гэнэ.

-Тэр ёсоор боллоо гэж хаан хашгирч гэнэ.

Хааны толгой дээгүүр том сэлмийг хоёр дахь удаагаа исгэрүүлэн эргүүлж:

-Олон гэмгүй улсыг хэлмэгдүүлсэн ухаан тэнэг нүглээ наманчилан, тэр улсын гэр бүлийнхэнд тэн хагас хөрөнгөө хувааж өгтүгэй! гэлээ. Хаан наминчлэн мөргөж:

-Хамаг хөрөнгийн хагасыг хэлмэгдсэн хүмүүсийн гэр оронд өгтүгэй! гэж бахирав.

Үгүй хүү сэлмийг хааны толгой дээгүүр гурав дахь удаагаа исгэрүүлэн эргүүлж::

-Эрх тушаал, эд хөрөнгөндөө ташууралгүй энх түвшин, эрхэм ёсыг үүрд сахиж, ард албатаа ямагт хүндлэн хайрлаж явна гэж ам тангарагаа өгөгтүн ! гэхэд хаан мөн л тонголзон:

-Хамаг бүгдээрээ тэгш жаргалтай байх төр ёс бадартугай ! гэж ам өчгөө өгөв гэнэ.

Ингэж Үгүй хүү ахынхаа амийг аварч, ард түмэнд ач тустай үйлсийг бүтээсэн үлгэр энэ билээ.

Ухаант дүү нар минь энэ явдал үлгэр боловч эрхбиш нэгэн сургаалтай биз ээ. Сурч бүтээхээс залхуурч, За гэхийн оронд Үгүй гэдэг зарим нэг явдал байдаг бол Үгүй нэрт энэ хүүгийн үлгэр юунаас учрыг тунгаараарай